

# БӨХӨНГИЙН ЭДЭЭ



*Бөхөнгийн экологи болон хамгааллын талаар  
мэдээлэл солилцох 6 хэл дээр гардаг хэвлэл*



© Евгений Полонский

Дэмжлэгтэйгээр  
Нийтэлсэн:



Нэмэлт дэмжлэг:



## АГУУЛГА

### Хэлэлцүүлэг

**Вячеслав Гагарин, Алексей Вайсман, Мария Воронцова, Сергей Гашев ба Владимир Кревер** Бөхөнгийн популяцид тулгарч буй асуудлуудад бууж өгөх нь хэтэрхий эрт байна.

### Шинэ мэдээ

**Карлин Самуэль** Бөхөн бөөнөөр хорогдож байгаа шалтгааныг судалж буй олон улсын багаас ирүүлсэн мэдээлэл

**Алёна Кривошеева** Казахстаны бөхөн хамгааллын асуудлыг хэлэлцсэн хурал

**Лиша Бирченаф** «Алтын дала» хамгааллын санаачлага байгууллага Амьтан ургамлыг хамгаалах олон улсын холбоотой хамтран ажиллаж байна.

**Александр Есипов** Узбекистанд «Сайгачий» БНГ дахин байгуулагдлаа.

**Кривошеева Алёна** Хамгаалалттай газар нутгийн менежмент ба хууль бус агнуурын эсрэг ажлын үр өгөөжийг дээшлүүлэх нь

**Путилин Александр** Устюртын өндөрлөгт бөхөнгийн шилжилт хөдөлгөөн саадгүй явагдах ёстой.

**Айгуль Айтбаева, Евгения Самтанова ба Рори МакКенн** ОХУ-ын ханын үзэсгэлэн 2016 - эрхэм зорилго биелэгдлээ!

**Наталья Шивалдова, Мухит Суттибаев, Айгуль Айтбаева, Буяна Чимеддорж** ОХУ, Узбекистан, Казахстан, Монголын алслагдсан орон нутгийн хүмүүс Бөхөн хамгаалах өдрийг тэмдэглэлээ.

**Алёна Кривошеева, Наталья Шивалдова** Хүүхдэд зориулсан боловсролын кемп: хүүхдийн байгаль хамгааллын хандлагыг дэмжих нь

### Хэвлэлийн мэдээ

Казахстанд бөхөн хууль бусаар агнасан 20 гэмт хэргийн шинжтэй тохиолдол бүртгэгдлээ.

Узбекистаны Фергана хотноо их хэмжээний бөхөнгийн эвэр хийгээд арьс хураагдав.

Хятадад бөхөнгийн эвэр хураагдлаа

### Өгүүлэл

**Буяна Чимеддорж ба бусад.** Баруун монголын бөхөнгийн тархалт ба шилжилт хөдөлгөөнд хүний суурьшил нөлөөлөх нь

**Штеффен Цутер, Альберт Салемгареев** Казахстанд 2016 онд хийгдсэн бөхөнгийн агаарын тооллогын үр дүн

**Владимир Калмыков, Мария Воронцова.** Степной ДЦГ-ын хавар

**Соня Данда ба бусад.** «Сайгачий» БНГ-н талаарх оролцогч талуудын ойлголтыг үнэлэх нь

### Зарлал

Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенци болон Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Залуу хамгааллын лидер хөтөлбөрөөс ивээн тэтгэж буй Бөхөн хамгаалах холбооны жижиг тэтгэлэгт хөтөлбөрийн 2016 оны ялагчийг зарлаж байна.

### Бөхөнгийн баатар

Владимир Калмыков, ОХУ

### Дурсамж

Николай Ткачев

Мария Карлштеттер

**Редакторын баг.** Хятад: Гуйхон Джан ([guihongzhang@foxmail.com](mailto:guihongzhang@foxmail.com)) & проф. Чжиган Цзян ([zhigangjiang@vip.sina.com](mailto:zhigangjiang@vip.sina.com)), Куйлонгийн боловсролын төв ХХК; Казахстан: Профессор А. Бекенов & док Ю.А. Грачев, Амьтан судлалын хүрээлэн & Алёна Кривошеева, КБТЗХН ([alyona.krivosheeva@acbk.kz](mailto:alyona.krivosheeva@acbk.kz)); Монгол: доктор Б.Лхагвасүрэн ([lkhaqvazeer@gmail.com](mailto:lkhaqvazeer@gmail.com)), ШУА, Ерөнхий болон Сорилын биологийн хүрээлэн & Б. Чимеддорж ([chimeddorj@wwf.mn](mailto:chimeddorj@wwf.mn)), ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар; Орос: Профессор Ю. Арылов, Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан судлах төв ([saiga-center@mail.ru](mailto:saiga-center@mail.ru)) & док А. Луцкекина, Экологи эволюцийн хүрээлэн ([saigak@hotmail.com](mailto:saigak@hotmail.com)); Узбекистан: Е. Быкова [Гүйцэтгэх редактор] & док А. Есипов, Амьтан, ургамлын генийн сангийн хүрээлэн ([esipov@xnet.uz](mailto:esipov@xnet.uz)); Их Британи: Профессор Е.Ж. Милнер-Гулланд [зөвлөх редактор], Лондонгийн эзэн хааны коллеж ([e.j.milner-gulland@imperial.ac.uk](mailto:e.j.milner-gulland@imperial.ac.uk)) & док. Давид Маллон [Шүүмжлэгч], ДБХХ, Туруутны мэргэжлийн баг, [d.mallon@zoo.co.uk](mailto:d.mallon@zoo.co.uk); График дизайныг А. Ганиева ([Alfiya\\_71@mail.ru](mailto:Alfiya_71@mail.ru)).

Бүх өгүүллийг бидний хэрэглэдэг 6 хэлний аль нэг дээр бичнэ үү. Өгүүллийг [esipov@xnet.uz](mailto:esipov@xnet.uz) хаягаар эсвэл редакторуудын аль нэг рүү илгээнэ үү. Бид жилд хоёр удаа гаргадаг. Сэтгүүл жилд хоёр удаа гардаг. Өгүүлэл бичих журмыг [www.saiga-conservation.com](http://www.saiga-conservation.com) хуудсаас эсвэл редакторуудаас англи болон орос хэл дээр авч болно. Хэрвээ танд асуулт гарвал өөрийн улсын Бөхөнгийн мэдээний редактортай эсвэл гүйцэтгэх редактор Елена Быковатай ([esipov@xnet.uz](mailto:esipov@xnet.uz)) холбогдоно уу.

Энэ дугаарыг онлайн хэлбэрээр [www.saiga-conservation.com](http://www.saiga-conservation.com), <http://saigak.biodiversity.ru/publications.html> болон <http://www.wildlifewarden.net/wcs/mini/saiga-chinese.pdf> сайтуудаас pdf форматаар, эсвэл хүсэлтийн дагуу сэтгүүл хэлбэрээр редакторуудаас англи, казах, хятад, монгол, орос, узбек хэл дээр авч болно.

## ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

*Редакторын тэмдэглэл: ОХУ Ховордсон зүйлийг хамгаалах улаан номонд бөхөнг оруулах тухай шийдвэр гаргасан талаар бид Бөхөнгийн мэдээний 20-р хэвлэлд мэдээлсэн билээ. Энэхүү шийдвэр ихээхэн маргаан дагуулсан. Ховор болон ховордсон амьтан, ургамал, мөөгийг хамгаалах улсын товчооны хөхтөн амьтдыг хариуцсан хэсэг баруун хойд Пре-Каспийн популяцийн тархац нутаг төдийгүй ОХУ-д бөхөн тархан байршиж буй бүх нутгийг хамруулах талаар ихээхэн санал өгч хэлэлцсэн болно. [Regulation.gov.ru](http://Regulation.gov.ru) цахим хуудсаар дамжуулан өргөн хүрээтэй хэлэлцүүлгийг эцсийн шийдвэр гаргахаас өмнө явуулсан. Өнөөдөр бид Вячеслав Гагарин болон ОХУ-ын бусад судлаачдын энэ асуудлыг тойрсон өгүүллийг хэвлэн хүргэж байна.*

**Бөхөнгийн популяцид тулгарч буй асуудлуудад бууж өгөх нь хэтэрхий эрт байна.**

**Вячеслав Гагарин**

**Зэрлэг амьтдыг гаршуулан үржүүлдэг мэргэжилтэн, [lab\\_z@mail.ru](mailto:lab_z@mail.ru)**

Зарим судлаачдын өөдрөг тооцооллоор, бөхөнгийн тоо баруун хойд пре-Каспийн бүс нутагт тогтвортой байгаа гэж үзэхийн сацуу адил туршлагатай, бусад гутранги үзэлтэй судлаачид тогтвортой буурч байгаа мэдээллийг өгдөг. Судлаачид ойрын ирээдүйд бөхөнгийн популяцийн тоо толгой нэмэгдэх ямар нэгэн хандлага ажиглагдахгүй байгаа гэсэн зөвхөн нэг асуудал дээр санал нийлж байна. Бөхөнг Улаан номонд оруулах хэрэгтэй эсэх талаарх маргаанд хандаж буй миний хандлага бол энэ нь зөвхөн агнуурын нөөцийг төдийгүй тухайн зүйлийг ч мөн адил булшлах хамгийн найдвартай арга юм. Хүн бүр ОХУ-ын Улаан ном гэж юу болохыг, тоо толгой багатай эсвэл багасаж байгаа зүйлийг аврах найдвар болохыг мэднэ. Энэ жагсаалтанд хамрагдсан аливаа зүйл энэ байдлаасаа ангижрах болно. Улаан номонд хамрагдсан хэдэн зүйл тоо толгойн хувьд өссөнийг өөрсдөөсөө асуу? Тэдний хэд нь хэвийн байдалдаа орж, нөхөн сэргэсний дараа Улаан номноос хасагдсан бэ? Хүн бүр хариултыг мэдэж байгаа. ОХУ-д Улаан номонд орсон зүйлүүдийг хамгаалах ажилд зарцуулагдах санхүүжилт нь агнуурын нөөцийг хамгаалах ажилд зарцуулагдаж байгаа хөрөнгөнөөс дутагдалтай, ихэнхдээ

бага байдаг. Нэмж хэлэхэд, энэ оронд Улаан номонд орсон зүйлүүдийг нөхөн сэргээх, хамгаалах талаарх хариуцлага хүлээх хэн нэгэн байхгүй эсвэл аливаа нэгэн үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээлэл, сурталчилгаа дутмаг байдаг.

Улаан номонд бөхөнг хамруулах талаар хэн чанга дуугарч чадах вэ? Хамгийн түрүүнд тухайн зүйлийн хамгааллын статусыг сөргөөр нөлөөлж болох ойлголтыг үл харгалзан Дэлхийн байгаль хамгаалах сан, Амьтны эрүүл мэндийг хамгаалах олон улсын төв зэрэг байгаль хамгаалах байгууллагууд байна. Төр засгийн байгаль хамгаалах байгууллага нь бөхөнг Улаан номонд оруулж, 'Бид боломжтой бүх арга хэмжээг авсан' хэмээн тэдний хэлсэнийг хүлээн зөвшөөрч, өөрсдийн "гарыг угааж" байна.

2013 онд батлагдсан № 150-F3 хуулиар олон улсын гэрээ конвенци, Улаан номонд орсон зүйлүүдийг хамруулан ихээхэн ач холбогдол бүхий биологийн зүйлүүдийн жагсаалтыг баталсан. Бөхөн энэ жагсаалтанд орсон. Холбооны улсын эрүүгийн хуулийн 258.1, 226.1 бүлэгт энэ жагсаалтанд орсон зүйлийг худалдаалах, хууль бусаар нийлүүлэхийг

## ХЭЛЭЛЦҮҮЛЭГ (үргэлжлэл)

хориглосон байдаг. Бөхөн нь Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенциар хамгаалагдсан учраас Улаан номонд хамрагдсан зүйлүүдтэй тэнцүү хэмжээнд хуулиар хамгаалагдсан гэж үзэж болно. Иймээс бөхөнг илүү эрчимтэй үйл ажиллагаа шаардагдах “Улаан номны хөнгөвчлөх эмчилгээнд” хамруулахад хэтэрхий эрт байна!

Тэдгээрт шаардлагатай байгаа эн тэргүүний арга хэмжээг агнуурын аж ахуйн менежерүүд сайн мэдэж байгаа. Юуны өмнө, бөхөнг аврах боломж

Халимагийн БНУ-ын гарт байгаа гэдгийг ойлгох нь чухал. БНУ-ын засаг захиргаа бөхөнг толгойны өвчин эсвэл аливаа нэгэн бодлогын хэрэглүүр болгохгүйгээр, байгалийн нөөцийн тогтвортой менежментэд шилжих эдийн засгийн өсөлтийн боломжит гарц болгон ашиглах шаардлагатай. Энэ нь бөхөнгийн хамгаалалд нийгэм, эдийн засгийн хөгжлийн хослол шаардагдана. Бөхөн нь хамгийн сайн судлагдсан амьтны нэг бөгөөд хэрвээ бодлого хэрэгжвэл санхүүгийн тогтвортой эх үүсвэр бий болж, бөхөнг нөхөн сэргээх нь цаг хугацааны асуудал болно.

## Хариу мэдэгдэл

*Алексей Вайсман*

***ОХУ, Ангийн хяналтын төв, орлогч захирал***

Би Улаан номны тухай В. Гагарины үг бүрийг хүлээн зөвшөөрч байна. Ховор амьтдын комиссын товчооны хөхтөн амьтдын Улаан номны хэсгийг хариуцсан гишүүний хувьд би бөхөнг хамгаалах хэрэгсэл болгон Улаан номонд хамруулах нь зохисгүй болохыг маш сайн мэдэж байна. Гэсэн хэдий ч, би Улаан номонд энэ зүйлийг оруулах талд санал өгсөн. Одоогоор зөвхөн тодорхой зүйл рүү чиглэсэн үндэсний хөтөлбөр нь тухайн зүйлийг хамгаалж чадна. Энэ нь юу ч хийлгүйгээр бөхөнг “Халимагийн байгалийн өв” гэж үзэж байгаа Халимагийн БНУ-ын Засгийн газарт чухал ач холбогдолтой юм. Эрүүгийн хуулийн 258.1 зүйлээр хууль бусаар бөхөн алсан, эсвэл арилжвал маш хүнд шийтгэл ноогдуулдаг. Гэсэн хэдий ч бөхөн их агнагдаж байгаа бөгөөд Халимагт бараг бүх хашаа эвэр худалдан авах зараар дүүрсэн байдаг. Хэн баригдаж шийтгэгдсэн байна вэ? Бараг нэг ч хүн үгүй! Нэг хос эврийн үнэ Халимагийн хөдөө

аж ахуйн салбарт ажиллагсадын дундаж цалинтай дүйцэж байна. Мотоциклтой яваа хоньчин түүнийг хөөн барьж «цалин» авахыг яавч эсэргүүцэж чадахгүй?

Тиймээс бөхөнг аврахын тулд бидэнд үндэсний хяналттай хөтөлбөр, асар их мөнгө хэрэгтэй. Энэ нь Улаан номоор дамжуулан, бөхөнг үндэсний статустай болгохыг шаардаж байна.

*Мария Воронцова,*

***Амьтдын эрүүл мэндийг хамгаалах олон улсын төвийн Орос дахь хөтөлбөрийн захирал***

ОХУ-ын Улаан ном нь ховор, ховордсон зүйл, популяцийг таньж тодорхойлох албан ёсны хэрэгсэл юм. Энэ нь тухайн зүйлүүдийн амьдрах орчны байдлыг хянаж, байгаль хамгаалах ажлыг төлөвлөхөд зайлшгүй шаардлагатай юм. Өнөөдөр Орос улсад зэрлэг ан амьтдыг хамгаалах зорилгоор хийж байгаа ажил маш бага, улс орныг хамарсан хууль бус агнуурын давалгаа өрнөж, зэрлэг ан амьтныг



хамгаалах засаг захиргааны шинэчлэлийн тогтолцоо цэгц муутай байна. Гэсэн хэдий ч, Улаан номонд оруулснаар Орос улс бар, саарал халим, хар өрөвтасын, хар сүүлт зэрэг зүйлийг бүрэн устах аюулаас авран хамгаалж, олон нийт, шийдвэр гаргагчдын анхаарлыг татаж чадсан бөгөөд хамгааллын үйл ажиллагаанд зарцуулагдах хөрөнгө босгож чадсан. Улаан ном нь хүний давуу талаар биш тухайн улсын бодит үйл хэрэг болдог. Улаан номонд бөхөнг оруулсанаар сүүлийн хэдэн жилд ОХУ-д болж байгаа маргааны объект байхыг зогсоох болно; янз бүрийн түвшинд ажиллаж байгаа үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн байгаль орчны бүтцийг нэгтгэх болно. Энэ нь хууль сахиулах байгууллага, олон нийтийн байгууллага нь хамгааллын үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцох боломжийг бий болгоно. Зүгээр л Улаан номонд бөхөнг оруулсанаар засгийн газрын эрх баригчид хатуу хяналтын дор их хөрөнгө босгох, тухайн зүйлийг хамгаалах цогц хөтөлбөр боловсруулж болно. Үүний дараа нь Халимагийн БНУ-ын эрх баригчид нь бөхөнг «толгойны өвчин» эсвэл улс төрийн, эдийн засгийн арга хэрэгсэл болгон хүлээж авахаа болино. Миний бие В. Гагарины ирээдүйд (бидний хамтын дэмжлэгтэйгээр) бөхөнг нөхөх сэргээх нь хөдөө орон нутагт эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжлийг хангах маш сайн боломжийг олгоно гэдэгтэй санал нэг байна.

.....

**Сергей Николаевич Гашев,**

**Тюмений Их сургуулийн Амьтан судлал, Эволюцийн экологийн тэнхимийн эрхлэгч**

Нэг талаас, В.Гагарины Улаан номонд нэгэн зүйл оруулах нь хангалттай биш бөгөөд түүний хамгааллын тодорхой арга хэмжээг томъёолсон байх хэрэгтэй гэсэн

бодол нь маш зөв юм. Ихэнх тохиолдолд (олон төрөл зүйлийн хувьд) энэ нь ан агнуурыг хориглох, түүний амьдрах орчныг хамгаалах үйл ажиллагаагаар хязгаарлагдаж байна. Энэ нь мэдээжийн хэрэг хангалттай биш! Ялангуяа бөхөнг нөхөн сэргээх хэрэгтэй байна. Улаан ном нь орон нутгийн болон холбооны аль алиных нь түвшинд хамгааллын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх зэрэг (бөхөн нь Сибирийн бар, Амарын ирвэстэй үнэмлэхүй тэнцүү байна) олгодог үндэсний баримт бичиг юм.

Бөхөнг Улаан номонд оруулсаны дараа хэрэгжүүлэх боломжгүй, эсвэл зөвхөн анчид л гүйцэтгэж чадах ямар тусгай арга хэмжээ байна гэж В.Гагарин зөвлөж байна вэ? Энэ логикийн дараа ямар ч ховор амьтад агнуурын зүйл биш л бол хамгааллын үйл ажиллагаа нэгэнт өнгөрсөн зүйл болох биш үү? Тэгэхээр Улаан Ном яагаад үр дүнгүй байна вэ? В. Гагарин агнуурын зүйлүүдээс илүү Улаан номонд орсон амьтдад маш бага санхүүжилт өгдөг гэсэн зөвхөн нэг л хариулт хэлсэн. Үүнийг нотлохын тулд бид юу хийж хичээх хэрэгтэй юм бэ. М. Званнецкийн хэлсэн алдартай үг нь «Та нар танд хамааралтай тойрогт байж, юу хийхээ мэдэх ёстой» ...

.....

**Владимир Кревер,**

**Дэлхийн байгаль хамгаалах сангийн Орос дахь хөтөлбөрийн газрын биологийн төрөл зүйлийн хамгаалал хариуцсан захирал**

Бөхөнгийн тоо толгойн бууралтын үндсэн шалтгаан болох хулгайн ан, орчны хомсдол, байгаль орчны доройтол зэргийг хангалттай судалж байна. Яагаад В.Гагарины бөхөнг Улаан номонд хамруулахгүй байхыг зөвлөсөн нэг шалтгаан нь Улаан номонд орсон зүйлээс илүүтэйгээр агнуурын менежмент нь илүү

### ХЭЛЭЛЦҮҮЛЭГ (үргэлжлэл)

санхүүжилт олох боломжтой байна гэжээ. Тэгвэл яагаад ийм эмгэнэлтэй байдалд бөхөн байгаа юм бэ? Бид үүнд хариулт олсон нь ямар ч улс төрийн хүсэл зориг байхгүй, мөн санхүүжилт хангалтгүй байгаа явдал юм.

Тэрээр санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөв гэж харж байна. Тиймээс улс төрийн оролцоо хэрэгтэй байна. Хэрвээ уг зүйл Улаан номонд байсан бол яаралтай арга хэмжээ авах шаардлагатайг нотлох нь илүү хялбар байх болно.

Эдгээр өдрүүдэд ОХУ-ын удирдах түвшний хүмүүс уг амьтдыг хамгаалах өөрсдийн сонирхлоо маш ихээр харуулж байна. Одоогоор энэ нь бар, ирвэс, цагаан баавгай, ирвэс, цагаан тогоруу болон бусад зэрэг билэг тэмдэг болсон зүйлүүдэд голчлон анхаарал хандуулж байгаа боловч ховор зүйлүүдэд мөн зохих хэмжээгээр анхаарал хандуулж болно.

Бид ховор зүйлүүдийг хамгаалах үр ашигтай механизм нь Улаан ном гэж үзэж байна. Гэсэн хэдий ч, Улаан номонд хамрагдсан зүйлийн хамгааллын арга

хэмжээний хэрэгжилтийг хангахад шинэчлэл шаардлагатай байна. Эхний алхам болох шаардлагатай хамгааллын арга хэмжээний цар хүрээ, зүйлийн зэрэглэлийг өргөжүүлэх зэргээр энэ жилээс хийгдэж эхэлж байна. Бөхөнг Улаан номонд оруулсанаар хуулийн дагуу Байгаль хамгаалах яам уг зүйлийн хамгаалал, санхүүжилт зэрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, стратегийг батлах, гүйцэтгэх үндэслэл болно.

Хууль бусаар хил давуулах (2261 ОХУ-ын Эрүүгийн хуулийн зүйл), хууль бус ан агнуур, эдийн засгийн ихээхэн ач холбогдол бүхий зэрлэг амьтдыг худалдаанд (2591 зүйл) тооцох эрүүгийн хариуцлагыг хулгайн анг хязгаарлах зорилгоор нэмэлт хөшүүрэг болгон ашиглаж болно. Гэсэн хэдий ч, энэ нь холбогдох шатны бүх байгууллагын хяналтын ажилтнуудын арга хэмжээгүйгээр үр дүнтэй байж чадахгүй. Улаан номонд бөхөнг оруулсанаар хууль бус ан агнуурын гэмт хэргээр баривчлагдсан хүмүүсийн төлсөн торгууль нэмэгдэж, хууль бус ан агнуур, амьдрах орчны доройтлын улмаас учирсан хохирлыг тооцоолоход



© Андрей Гилёв

## Шинэ мэдээ

ашигласнаар уг зүйлийн эдийн засгийн үнэ цэнэ нэмэгдэхэд хүргэх болно. Энэ бол хулгайн анчдад бөхөнг агнах нь ямар их үнэтэй болохыг мэдрүүлэх болно. Хамгийн гол нь одоогоор анчид, эсвэл байгаль хамгаалагч нарын хэн нь ч энэхүү нөөцийн асуудлыг хянаж чадахгүй байгаад гол асуудал оршино.

Энэ нь манай орны амьтны аймгийн нэг хэсэг болох бөхөн хэрхэн хамгаалагдаж, тогтвортой ашиглагддаг байгалийн нөөцийн зэрэглэл рүү оруулж байна. Миний бие ховор зүйлийн хамгаалал бол агнуурын аж ахуй эрхлэгчдийн үүрэг хариуцлагатай холбоотой гэдгийг уншигчдад сануулж байна. Бид юуны тухай яриад байна вэ?

### Бөхөн бөөнөөр хорогдож байгаа шалтгааныг судалж буй олон улсын багаас ирүүлсэн мэдээлэл

*Карлин Самуэл, Бөхөн хамгаалах нийгэмлэг, [mail@saiga-conservation.com](mailto:mail@saiga-conservation.com)*

Бөхөн бөөнөөр хорогдсон 2015 оны 5 сараас эхэлсэн дээжний шинжилгээ үргэлжлүүлэн хийгдэж, гол шалтгааныг тус лабораториас мал, амьтдыг үхэлд хүргэдэг цусархаг үжил үүсгэхэд нөлөөлдөг *Pasteurella multocida* бактери гэж тодорхойлсон байна. Сүүлийн гистопатологийн судалгаа энэ оношийг баталжээ. Хамгийн сүүлийн үеийн оношлогооны аргыг ашиглан, тухайлбал вирус болон бусад халдварт бодисыг тодорхойлох оролдлого үр дүнгээ өгөөгүй хэдий ч бүх тохиолдолд *Pasteurella* бактериар халдварлагдсан болох нь батлагдсан байна. Эндээс энэ нь цусархаг үжилд тухайн популяци өртөмтгий гэсэн магадлал бага байна.

Тухайн судалгааны багийнхан өмнөх судлаачдын зохиол бүтээлийг өргөн хүрээнд шүүж үзсэний эцэст *Pasteurella* бактерийн тодорхой төрлөөс үүсэн гарах цусархаг үжил өмнө нь тал хээрийн экосистемд байх зэрлэг болон гэрийн тэжээвэр амьтдын хорогдлын шалтгаан болдог ч бөхөн дээр ажиглагдсан шиг халдварлалтын түвшин, үхэл хорогдол хэзээ ч 100% байгаагүй болохыг тайлбарласан хачирхалтай баримт олж авсан юм. Энэ нь өнгөрсөн жилийн бөөнөөр үхэж хорогдсон явдал нь өвөрмөц, урьд өмнө нь байгаагүй биологийн үйл явдал болохыг харуулна. Иймээс ийм ер бусын



© Сергей Хоменко

арга хэмжээг тайлбарлаж чадах хүрээлэн буй орчны дарамт зэрэг хам хүчин зүйлсийн боломжит утгуудыг оролцуулан эрчимтэй судалгааны ажил хийж байна.

Казахстанд болсон бөхөн олон тоогоор хорогдсон явдал нь одоо явагдаж байгаа болон хүнд хэцүү аюул заналаас үлдэж хоцорсон нэн ховор амьтдыг хамгаалахын ач холбогдлыг онцлон харуулж байна. Бараг популяцийн 90%-ийг адлсаны дараа, Бетпак-Далагийн бөхөнгийн популяцийн нөхцөл байдал эмзэг болж эхэлсэн. Бөхөн хамгаалах холбооны гишүүн Е.Ж.Милнер-Гулланд «Хулгайн ан, Хятадын уламжлалт анагаах ухаан, Азийн хэд хэдэн оронд ашиглагддаг маш үнэтэй түүхий эд болох



### Шинэ мэдээ (үргэлжлэл)

эврийг нь авах зорилгоор ялангуяа эр амьтдыг буудаж байгаа нь цаашид тоо толгой цөөрөхөд хүргэж байна» гэж мэдээлсэн. Казахстаны засгийн газрын Ой, зэрлэг амьтдыг хамгаалах хорооноос саяхан хийсэн мэдэгдэлд 2015 онд бөхөнг хулгайгаар агнасан хэрэг өссөн болохыг мэдээлсэн байна (2014 онд 79 байсан бол 2015 онд 107 тохиолдол).

Судлаачид одоогийн байдлаар 2015 оны 5 сараас хоруу чанартай болж, ийм асар их хэмжээгээр нь хорогдоход хүргэсэн хэдий ч хэвийн үедээ бөхөнгийн амьсгалын замд амьдардаг *Pasteurella* нянгийн цаад уг учир шалтгааныг олохоор хичээж байна. Өргөн уудам, янз бүрийн ургамалжилтын хэв маягтай амьдрах орчинд бөөнөөрөө хорогдсон, амьтад бараг нэгэн зэрэг шахуу үхсэн үеэс эхлэн эхэн үедээ таамаглаж байсан хүрээлэн буй орчин дахь хортой бодис эсвэл хортой ургамалд хордсон гэх үндэслэл эргэлзээтэй болж эхэлсэн. Сүүлийн үед хийгдэж буй лабораторийн шинжилгээний үр дүнгээр тухайн амьтад нь замаг буюу мөөгөнцрийн гаралтай хорт бодис, хүнд металл, эсвэл түлш зэргээс хордсон ямар ч ул мөр ажиглагдаагүй. Харин эсрэгээрээ, бүх эмгэг нь хурдацтай үхжил, нянгийн гадаад хоруу чанарын цочролтой шууд хамааралтай байсан. Цаашилбал, бөөнөөр үхсэн газрын хөрс, усны дээжинд ямар нэгэн байгаль орчны хорт бодисын ямар ч ул мөр илрээгүй байна.

Үүний үр дүнд, энэ жилийн 5 сард доор дурдсан экспидецийн судалгаа шинжилгээ нь бөхөнд хоруу чанартай, популяцид өргөн тархсан бактерийн шинж чанарыг нөхцөлдүүлэх хүчин зүйлд анхаарлаа хандуулж байна. Эдгээр хүчин зүйлсэд цаг агаар, шим тэжээлийн байдал, ургамалжилт, бэлчээрийн хөрсөн дэх бактерийн түвшин, хөрсний эрдэс бодист үзүүлэх үерийн нөлөө болон бусад хүчин



© Сергей Хоменко

зүйлс зэрэг бие биеэс ялгаатай газруудад ижил байж болох хүчин зүйлүүд орно. Энэ нь өмнөх жилүүдэд ямар ч амьтан үхээгүй төллөлтийн үедээ бөөгнөрсөн газар, 2015 оны бөөнөөр хорогдсон газрын хоорондох ялгааг ойлгох нь чухал юм.

Энэхүү үр дүн нь Лондонгийн их сургуулийн Мал эмнэлгийн коллежийн эрдэмтдээр ахлуулсан уг олон улсын эрдэм шинжилгээний төсөлд оролцогч бүх талууд, тухайлбал, Казакстан Биологийн аюулгүй байдлын асуудлын эрдэм шинжилгээний хүрээлэн (RIPBS), Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг (КБТЗХН) нь Оксфордын их сургууль, Бристоллын их сургууль, Умеагийн Шведийн Хөдөө аж ахуйн их сургууль, мөн НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын хамтын хүчин чармайлтын үр дүн юм. Энэ ажилд шаардагдсан санхүүжилтийг Их Британийн Засгийн газрын байгаль орчны судалгааны зөвлөл ивээн тэтгэсэн. Цаашдын дэмжлэгийг Бөхөн хамгаалах холбоо, Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ, Ховордсон



зүйлийг хамгаалах нийгэмлэг, Амьтан, ургамлыг хамгаалах олон улсын нийгэмлэг өгч байв. КБТЗХН нь Франкфуртын Амьтан Судлалын Нийгэмлэг, Шувуу хамгаалах эзэн хааны нийгэмлэг, Олон улсын амьтан, ургамлыг хамгаалах нийгэмлэгийн тусламжтай хэрэгжиж буй Алтын Дала байгаль хамгаалах санаачлага төслийн хүрээнд хувь нэмэрээ оруулж байна.

Хулгайн ангийн эсрэг ажлыг үргэлжлүүлэн хийх нь Бетпак-Дала бөхөнгийн популяцийг хамгаалахад гол түлхүүр болох бөгөөд бөхөн бөөнөөр хорогдсон хохирлыг нөхөн сэргээхэд цаг хугацаа хэрэгтэй. Яам хоорондын болон агентлаг хоорондын мөн Казахстаны Засгийн газар энэ жил хэрэгжих бөхөн хамгаалах үйл ажиллагаа, жагсаалтыг хэсэгчлэн боловсруулсан байна. Казакстаны Биологийн аюулгүй байдлын асуудлын эрдэм шинжилгээний хүрээлэн болон КБТЗХН-ийн аль аль нь улмаар олон улсын эрдэм шинжилгээний ажил болон засгийн газраас байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд хоорондын уялдаа холбоог бий болгоход нэг хэсэг болсоор ирсэн.

Цаашид ийм бөөнөөр үхэх үзэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэлэлцсэн байна. Харин Эзэн хааны Мал эмнэлгийн коллежийн профессор Ричард Кок хэлэхдээ: «Тухайн зүйлийн зан авирын онцлогт тулгуурлавал бөхөнгийн цусархаг үжилийн эсрэг авч хэрэгжүүлэх ямар ч урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа боломжгүй бөгөөд вакцинжуулах механизм дутагдалтай. Аэрозольжсон вакциныг агаараас шүрших хийгээд бусад арга хэрэгслийн алин ч тэднийг вакцинжуулах оролдлогын улмаас үүсэх стрессээс үүдэн өөрөө үхэлд хүргэх магадлалтай байж болох юм. Нэгэнтээ хүрээлэн буй орчны өдөөгчид, хамтын хүчин зүйлс тодорхойлогдсон учир хөндлөнгийн оролцоог дахин үнэлэх болно» гэжээ.

Үүний зэрэгцээ, өвчний дэгдэлтийн үед явагдаж буй судалгаа шинжилгээний үйл ажиллагаа нь үлдсэн популяцийн хамгаалалтыг сайжруулахтай нийцэж байгаа нь чухал ач холбогдолтой юм.



© Андрей Гилёв

## Шинэ мэдээ (үргэлжлэл)

### Казахстаны бөхөн хамгааллын асуудлыг хэлэлцсэн хурал

*Алёна Кривошеева, Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг, [alyona.chukhatina@acbk.kz](mailto:alyona.chukhatina@acbk.kz)*

Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг Казахстаны бөхөн хамгааллын асуудлыг хэлэлцэх зорилгоор олон улсын семинарыг Алтын Дала байгаль хамгаалах санаачлага төслийн нэг хэсэг болгон Ой, ан амьтан хамгаалах хороо, Хөдөө аж ахуйн яамны дэмжлэгтэйгээр 2016 оны 4 сарын 5-6 нд зохион байгуулсан. Семинарт Казахстан болон бусад улс орны; тухайлбал, Ой, ан амьтан хамгаалах хороо, Охотзоопром, Нохой судлалын төв, Улсын төсвийн хороо, Сангийн яам, Биологийн аюулгүй байдлын асуудлын эрдэм шинжилгээний хүрээлэн, Алтын Дала байгалийн нөөц газар, Иргиз Тургай байгалийн нөөц газар, Франкфуртын Амьтан Судлалын Нийгэмлэг, Шувуу хамгаалах Эзэн хааны нийгэмлэг, Олон улсын амьтан ургамал хамгаалах нийгэмлэг, Эзэн хааны мал эмнэлгийн коллеж зэрэг байгууллагын бөхөн судлаач мэргэжилтнүүд оролцсон.

Оролцогчид Казахстаны бөхөн хамгаалал, хяналт тавьсан тухай тайланг сонсож, хамгааллын асуудал; бөхөнгийн эвэр хууль бус худалдааг хянахад нохой ашиглах; Зимбабвегийн хулгайн ангийн эсрэг үйл ажиллагаа; хөдөлгөөнт эргүүлийн үр дүнг нэмэгдүүлэхэд SMART хөтөлбөрийг ашиглах; 2015 онд Бетпак-Дала бөхөнгийн популяци олноор хорогдсон үзэгдлийг судалсан лабораторийн судалгааны үр дүнтэй танилцсан.

Ажлын хэсгүүд нь Казахстаны бөхөн хамгааллын одоогийн нөхцөл байдал, давуу болон сул талыг онцлон хэлэлцсэн. Хэлэлцүүлэгт хулгайн ангийн эсрэг үйл ажиллагааг сайжруулах, бөхөн хамгааллыг нэмэгдүүлэх талаар дийлэнх санал тавигдаж байв. Хэлэлцүүлэгт



Хуралд оролцогчид. Бүлгээр ажиллаж байгаа нь . © КБТЗХН

өндөр түвшний шийдвэр гаргагчид болон орон нутгийн байгаль хамгаалах албан тушаалтан аль аль нь оролцсон. Бөхөнгийн өвчинд онцгой анхаарал хандуулсан бөгөөд хэлэлцүүлэгт бөхөнгийн популяцийн эрүүл мэндийг тогтвортой хянах, явуулын цусны дээж авах болон өвчний эхний шинж тэмдэг илрэх үед хийгдэх үйл ажиллагаа зэрэг асуудал багтсан байна. Хэлэлцүүлгийг үндэслэн 56 үйл ажиллагаанаас бүрдсэн 8 том хэсэгт хуваасан шийдвэр гаргасан. Үүнд дараах чухал ач холбогдолтой асуудалтай холбогдох шийдвэр орсон байна:

- Зэрлэг ан амьтан хамгаалах ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах;
- Гааль, хил хамгаалах байгууллагын ажилтнуудад зориулсан удирдамжийн дизайн, CITES-ийн сургалт зохион байгуулахад туслалцаа үзүүлэх
- Улсын хил дээр, улс орны дотор аль алинд нь бөхөнгийн гаралтай эд эрхтнийг тодорхойлоход нохой ашиглах хөтөлбөрийг сайжруулах;
- Орон нутгийн иргэдийн орлогын эх

үүсвэрийг нэмэгдүүлэхэд шинэ санаачлага нэвтрүүлэх;

- Орон нутгийн иргэдийн болон тосгоны сургуулийн хүүхдэд боловсрол олгох, мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилготой хөтөлбөрийг цаашид хөгжүүлэх (сүүлийн үеийн мэдээллийн эх үүсвэрийг ашиглан);

- Эрх бүхий байгууллагын шийдвэрээр бөхөнгийн популяцийн өвчний дэгдэлтийн үед хурдан ажиллах зорилгоор Стандарт үйл ажиллагааны журмыг эцэслэх;

- Төллөлтийн болон бөхөн барих үед (цусны дээж авах үед) халдвар судлалын системтэй хяналтыг бий болгох.

**Алтын дала хамгааллын санаачлага байгууллага Амьтан ургамлыг хамгаалах олон улсын холбоотой хамтран ажиллаж байна.**

*Лиша Бирченаф, Амьтан, ургамал хамгаалах олон улсын нийгэмлэг, [liesje.birchenough@fauna-flora.org](mailto:birchenough@fauna-flora.org)*

Бөхөнгийн байгаль дээрх аюул занал, 2015 оны бөөнөөр үхсэн үзэгдэл, хийгдсээр байгаа хулгайн ан зэрэгт чиглэгдсэн энэ жилийн 4 сард Астанад болсон бөхөн хамгааллын төлөвлөлтийг хийх хуралд оролцогчид Казахстан дахь метапопуляцийн түвшинд тухайн зүйлийг хамгаалахад чиглэсэн илүү нэгдмэл, цогц арга хэмжээ авахыг хүлээн зөвшөөрсөн.

Бид Казахстаны бөхөнгийн гурван популяцийн тархац нутгийн хэмжээнд бүх арга хэмжээг яаралтай төлөвлөх шаардлагатай бөгөөд үүнийг хийхийн тулд ландшафтын түвшинд уян хатан, бат бөх хамтын ажиллагааг бий болгох хэрэгтэй. Франкфуртын амьтан судлалын нийгэмлэг, Шувуу хамгаалах Эзэн хааны нийгэмлэг Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг, Казахстаны Засгийн газар аль хэдийн Алтын дала (Алтан тал) хамгаалах санаачлага (ADCI) төсөл дээр хамтран ажиллаж, Төв Казахстаны Бетпак-Далагийн ландшафтын хамгаалалд анхаарлаа хандуулж байна. Энэхүү санаачлага нь КБТЗХН-ээр дамжин хэрэгжиж байгаа бөгөөд 2015 онд бөхөн бөөнөөр хорогдох хүртэл хамгийн амжилттай хэрэгжүүлсэн ажил нь бөхөнгийн тоо толгойг өсгөх,

хамгаалахад ихээхэн амжилт гаргасан явдал юм. Алтын Дала хамгааллын санаачлага төсөл болон Амьтан ургамлыг хамгаалах олон улсын нийгэмлэгээс хэрэгжүүлж байгаа Устюртын санаачилга нь бэрхшээл, арга барил, хамтрагч зэрэг олон талаараа адил төстэй байна. Бид ландшафтын түвшинд үйл ажиллагааг илүү үр дүнтэй, харилцан ашигтай байлгах зорилгоор уг хоёр санаачилгын төсөл хоорондын ойр дотно хамтран ажиллах боломжийг судалж байна. Үүний үр дүнд нь Алтын дала хамгааллын санаачлага төслийн удирдах зөвлөлийн уулзалтын үеэр гол хамтран ажиллагч болох Амьтан ургамлыг хамгаалах олон улсын нийгэмлэг уригдсан бөгөөд төсөл хэрэгжих бүс нутгийг өргөжүүлсэн. Ингэснээр төсөлд хамрагдах газар нутагт Уралын ландшафтыг оруулан өргөжүүлэх, «Алтан Дала» санаачилгад хамрагдах нутгийг мөн хамруулан гурван бөхөнгийн популяци, бөхөн амьдрах ландшафтыг (120 сая га) өргөжүүлэхээр тохиролцсон байна. Алтын дала хамгааллын санаачлага төслийн бүх түншүүд энэ хамтын ажиллагаа Казахстаны бөхөнгийн хамгаалал илүү сайн, илүү үр дүнтэй хамтран ажиллах боломж олгоно гэдэгт найдаж байна.



## Шинэ мэдээ (үргэлжлэл)

### Узбекистанд «Сайгачий» БНГ дахин байгуулагдлаа.

Александр Есипов, Бөхөн хамгаалах нийгэмлэг, [esipov@xnet.uz](mailto:esipov@xnet.uz)



© Александр Есипов

Узбекистаны Сайд нарын зөвлөл “Сайгачий” ландшафтын нөөц газрыг байгуулах Узбекистаны Байгаль хамгаалах улсын хорооны (Госкомприрода) саналыг баталлаа. Энэ шийдвэр нь Госкомприрода, Узбекистаны Шинжлэх Ухааны Академи, ДДБОС/ НҮБХХ-ийн төсөл «Узбекистаны газрын тос, байгалийн хийн салбарын бодлогод Биологийн олон янз байдлын асуудлыг тусгах» төсөл, Бөхөн хамгаалах эвсэл, Амьтан, ургамал хамгаалах олон улсын нийгэмлэг, Байгаль хамгаалах Витлей сан зэрэг тус БНГ-ын статус, газар

нутгийн хамгааллыг сайжруулах чиглэлээр ажилладаг олон бие даасан шинжээч, байгууллагын ажлын оргил юм. Ингэснээр энэхүү тусгай хамгаалалттай газар нутгийг үүсгэн байгуулах, Каракалпакстаны Устюртын хойд хэсгийн өвөрмөц газар нутгийг болон биологийн төрөл зүйлийг хамгаалах, бөхөнгийн популяцийг нөхөн сэргээхэд шинэ үе шатыг нээж байна. Ландшафтын нөөц газрыг бий болгосноор байгаль хамгаалах, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах чиглэлд орон нутгийн иргэд, газар эзэмшигчдийг нэгтгэх шинэ боломж нээгдэж байгаа юм.

“Сайгачий” БНГ нь одоо байгаа Сайгачий ДЦГ-т суурилсан, «цаасан парк»-ны сонгодог жишээ байсан. Уг нөөц газар нь өөрийн газар буюу ажилтантай хэзээ ч байгаагүй бөгөөд түүний зорилго, бүтцийг хэд хэдэн удаа өргөжүүлж, өөрчилж байсан боловч бөхөн төллөх газрыг хамгаалах түүний үндсэн зорилго хэзээ ч үр дүнтэй биелэгдэж байсан удаагүй. Уг өөрчлөн байгуулалтаар уг нөөц газарт голчлон байгаль хамгаалах улсын байцаагчийн хамт



© Александр Есипов




© Александр Есипов

олон нийтийн байцаагч нар ч ажиллаж болно.

Хариуцан хамгаалах газар нутгийн хэлбэр өөрчлөгдөж, Казахстан улсын хил, Устюртын зүүн даланд ихээхэн ойртож, баруун хойд зүгрүү хандсан байна (Зураг 1). Эдгээр Каракалпакистаны Устюртын бөхөн амьдрах орчин хамгийн сайн юм.

Энэхүү нөөц газар нь онгон бүс болон орчны бүс зэрэг 5 газраас бүрдсэн нийт 628.300 га талбайтайгаас 219.800 га нь орчны бүс болно. Узбекистаны хамгийн том хамгаалалттай газар нутагт хамаарах энэ нутаг нь Бруней эсвэл хоёр Люксембургээс ч том байна. Ландшафтын нөөц газрын ихэнх нь (ойролцоогоор 95%) Кунград дүүрэгт байна. Үлдсэн хэсэг нь Арал тэнгисийн ойр орчмын нутгийг хамарч Муйнак дүүрэгт байдаг.

Сайгачий нөөц газрын захиргаа Каракалпакистан тосгонд байрлах бөгөөд Байгаль орчны улсын хорооноос удирддаг. Байгаль хамгаалагч нарын хээрийн суурин аль хэдийн гол цэгүүд дээр баригдсан бөгөөд бартаат замын тээврийн хэрэгсэл, хээрийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, мэдээлэл дамжуулах





### Шинэ мэдээ (үргэлжлэл)

станцаар хангасан ДДБОС/НУБХХ-т талархаж байна.

Хууль тогтоомжийн дагуу нөөц газрын онцгой бүсэд газар, ургамал, амьтны аймаг, байгалийн бусад элементүүдийг эдийн засгийн зорилгоор ашиглах нь хориотой бөгөөд байгаль орчныг хамгаалах газар болох болно. БНГ-ын зорилго нь байгаль хамгаалах; судалгаа, мониторинг тогтолцоог сайжруулах; шинжлэх ухааны ажилтан, байгаль хамгаалах мэргэжилтнүүдийн сургалт зохион байгуулах; экологийн боловсрол олгох явдал юм. Судалгааны үйл ажиллагаа нь Узбекистаны Шинжлэх Ухааны Академид түшиглэн явагдах бөгөөд бусад шинжлэх ухааны байгууллага, их дээд сургууль, орон нутгийн болон олон улсын эрдэмтэд урт хугацааны судалгааг гүйцэтгэх болно.

Сайгачий нөөц газар, түүний орчны бүс, түүнчлэн бусад объектын хил хязгаарыг газарт суулгасан зарлал, бичлэг, бусад

тэмдгүүдээр тэмдэгжүүлсэн болно. Орчны бүсэд БНГ-ын захиргааны зохицуулалттайгаар төлбөртэй автозам, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн засвар, жуулчдад зориулсан барилга, байгууламж барих; геологи хайгуул, бэлчээрийн чиглэлээр дэд бүтэц байгуулах боломжтой. Харин орчны бүсэд уул уурхай, хий дамжуулах хоолойн болон бусад аж үйлдвэрийн дэд бүтцийг барих; шинэ зам барилгын ажил хийх боломж хязгаарлагдмал байна. Ан хийх, загас барих, пестицид ашиглах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.


Тиймээс, Узбекистан улс нь Устюртын байгалийн өвөрмөц экосистем, түүний гол зүйл болох бөхөнг хамгаалах идэвхтэй механизм байх зорилготой «Сайгачий» ландшафтын нөөц газар луу шилжих өөрчлөлтийг амжилттай хийж байна. Энэ нь Узбекистанд устаж үгүй болоход ойрхон байгаа бөхөнг авран авч үлдэхэд асар их ач холбогдолтой билээ.

### Хамгаалалттай газар нутгийн менежмент ба хууль бус ан агнуурын эсрэг ажлын үр өгөөжийг дээшлүүлэх асуудалд

*Алёна Кривошеева, Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг, [alyona.chukhatina@acbk.kz](mailto:alyona.chukhatina@acbk.kz)*

КБТЗХН болон бусад хамтрагч байгууллагаас хэрэгжүүлсэн Алтын Дала байгаль хамгаалах санаачлага (ADCI) төсөл нь Алтын Далад байгаль хамгаалах санаачлагын хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн үр ашигтай менежментийг бий болгосноор өөрсдийн зорилгодоо хүрч чадах юм. Таван жилийн хугацаанд хэрэгжих тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө нь үр дүнтэй менежментийн нэг чухал арга хэрэгсэл юм.

Бетпак Дала бөхөнгийн популяцийн төллөх, нүүдлийн газар хамгаалах зорилготой Алтын Дала нөөц газар нь ямар ч албан



Хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлт семинарт оролцогчид. Гэрэл. © КБТЗХН

ёсны менежментийн төлөвлөгөө байдаггүй учир бид 2016 оны 8 сарын 3-4-нд Костанай аймгийн Амангелди тосгонд нөөц газрын удирдлагын төвд менежмент төлөвлөгөөг



боловсруулах семинар зохион байгууллаа. КБТЗХН-ээс санаачилсан энэхүү үйл ажиллагааг Шувуу хамгаалах эзэн хааны нийгэмлэг, Ой, хөдөө аж ахуйн яамны амьтдын хорооноос дэмжиж, ивээн тэтгэсэн байна. Ой, зэрлэг ан амьтдын хорооны албан тушаалтан, Алтын Дала нөөц газар, Иргиз Тургай БНГ болон Коргылзан нөөц газрын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн зэрэг 30 орчим хүн оролцлоо.

Оролцогчид менежмент төлөвлөлтийн онолыг хэлэлцэх, тусгай хамгаалалттай газар нутаг тус бүрийн онцлог шинж чанарыг судлах, гол аюул заналд дүн шинжилгээ хийх, үндсэн чиг үүргийг тодорхойлох, урт хугацааны зорилгыг тодорхойлох гэх мэт асуудлыг хэлэлцсэн. Үүний зэрэгцээ тэд хараахан батлагдаагүй байгаа Алтын Дала нөөц газрын менежментийн төлөвлөгөөг дахин нягталсан. КБТЗХН мөн улсын байцаагч, шинжлэх ухааны судлаачдад зориулсан GPS-ийн чиглүүлэгчийг ашиглан хяналт-шинжилгээний мэдээлэл цуглуулах, саяхан сайжруулсан мэдээллийн санд өгөгдөл оруулах талаар сургалт зохион байгуулсан.

КБТЗХН, Бөхөн хамгаалах холбоо нь 2016 онд Алтын Дала болон Иргиз Тургай улсын байгалийн нөөц газарт хулгайн ангийн эсрэг үйл ажиллагааг дэмжих чиглэлээр хамтарсан төсөл хэрэгжүүлэн, нөөц газрын байгаль хамгаалагчдын ажиллах нөхцлийг дээшлүүлэх, тэдгээрийн хулгайн ангийн



эсрэг ажлын үр өгөөжийг сайжруулахын тулд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. Төслийн хүрээнд камер, ширээний болон зөөврийн компьютер, хоёр нүдний дуран, GPS, майхан болон унтлагын уут зэрэг нийт 92 нэр төрлийн багаж хэрэгсэл худалдан авсанаас 43-ийг нь Алтын Дала нөөц газарт, 49-ийг нь Иргиз Тургай нөөц газарт тус тус өгсөн. Эдгээр тоног төхөөрөмжийн үр дүнтэй ашиглалтанд хяналт тавина. Энэ төслийн санхүүжилтийг 2015 онд бөхөн олон тоогоор үхсэний дараа бөхөн хамгааллыг дэмжих зорилгоор Бөхөн хамгаалах холбооноос гаргасан хүсэлтийн дагуу Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ гаргасан.

Хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлт семинарт оролцогчид. Гэрэл зургийг КБТЗХН ; Иргиз Тургай Улсын БНГ-ын ажилтнууд хээрийн тоног төхөөрөмж хүлээн авч байгаа нь. Гэрэл зургийг КБТЗХН.


**Устюртын өндөрлөгт бөхөнгийн шилжилт хөдөлгөөн саадгүй явагдах ёстой.**

***Александр Путилин. Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг, [aleksandr.putilin@acbk.kz](mailto:aleksandr.putilin@acbk.kz)***

Казахстан нь 2011 оны намраас Узбекистан, Туркменистантай хил залгаа нутгийнхаа улсын хилийн дагуу 1.7 м-ийн өндөр, 8 эгнээ өргөстэй төмөр утаснаас бүрдэх торон хашаа барьж эхэлсэн. Барилгын

ажил 2012 оны сүүлээр дууссан. 150 орчим км үргэлжлэх хилийн хашаа Устюртын бөхөнгийн популяцийн амьдрах орчныг хувааж байгаа ба уг популяцийн тоо толгойн бууралт нь үргэлжилсээр байгаа нь

## Шинэ мэдээ (үргэлжлэл)



Зураг. Казахстан, Узбекистаны хоорондох Устыуртын тал дээр хилийн хашаа. 2016 оны 6 сар

хамгийн их санаа зовоож байгаа асуудал юм. Казахстаны Устыуртын тал нутагт бөхөн хамгийн их цагаа зарцуулдаг хэдий ч, өвөл нь хоёр орны хооронд хилээр дамжин Узбекистан руу нүүдэллэн ордог. Хилийн торон хашаа нь Устыуртын тал нутаг дахь бөхөнгийн амьдрах орчныг бууруулснаар өөрсдийн өвөлждөг газраа хүрч чадахгүй болно. Бөхөн хилийн торон хашааг нэвтрэн гарч чадахгүй тул тааламжтай биш нөхцөлтэй нутагт үлдэх бөгөөд идэш тэжээлийн дутагдал нь олон тоогоор үхэх байдалд хүргэж, улмаар популяцийн бууралт ажиглагдах болно. Өвлийн улиралд бөхөн нь идэш тэжээлийн дутагдал болоод температурын бууралтанд ихээхэн мэдрэмтгий байх ба хавар хойд зүгт байрлах сайн бэлчээрт хүрч чадахгүй болно.

Энэхүү нөхцөл байдалд тулгуурлан бөхөнгийн шилжилт хөдөлгөөнд торон хашааны сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжийг өгсөн 2013 оны тайланг Франкфуртын амьтан судлалын нийгэмлэг, Ургамал, амьтны олон улсын нийгэмлэг, Нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенци боловсруулсан (<http://www.cms.int/en/publication/> бөхөнд зориулсан гарц гарам сонгох). Тухайн тайланг боловсруулсан хүмүүс бөхөнг саадгүй нэвтрэх нөхцлийг хангах зорилгоор доод эгнээний утсыг авах боломжит хувилбарыг таницуулсан.

Уг тайланд дурдагдсаны дагуу КБТЗХН-ээс гаргасан албан ёсны хүсэлтийг Казахстаны БНУ-ын Үндэсний аюулгүй байдлын хорооны хил хамгаалах алба харгалзан үзэж, бөхөнгийн тархац нутгийн хүрээнд



1 км-ийн интервалтайгаар төмөр утасны доод талын 3 үеийг авах боломжтой гэж мэдэгдсэн. Ийм өөрчлөлт хийсэн эсэхийг тогтоох зорилгоор Алтын Дала байгаль хамгаалах санаачлага дор КБТЗХН-аас зохион байгуулсан экспедицийн судлаачид Охотзоопром, Хил хамгаалах албатай хамтран 2016 оны зургадугаар сарын 19-21-ны хооронд үзлэг шалгалт хийсэн.

Энэхүү хяналтын ажил Казахстаны баруун хил дээр орших Актобе аймгаас эхэлсэн бөгөөд Арал тэнгисийн бүс нутагт дууссан. Хяналт шалгалтын явцад баг нь хил хамгаалах алба нь үүргээ гүйцэтгэсэн гэдгийг тогтоож, бөхөнгийн 125 сэг зэмийг цэвэрлэсэн. Үүнээс гадна 11 км урттай, тор багатай хэсэгт (Зураг) мөр цөөн тэмдэглэгдсэн.

Хоёр орны хоорондох Устюртын бөхөнгийн популяцийн чөлөөт шилжилт хөдөлгөөнийг хангахын тулд хулгайн анг хянах нэмэлт



Хашааны бүтцийн өөрчлөлт: а- 150 км урт хэсэг дээр; б - 11 км урттай хэсэг дээр. Зургийг Александр Путилин

арга хэмжээ авах хэрэгтэй. Хяналт нь том сүрэг үүсгэн бөөгнөрч, тухайн амьтан хулгайн анчдын хувьд хялбар бай болдог бөхөнгийн нүүдэл шилжилтийн үед хийгдэх ёстой. Энэ нь хилийн хоёр талд шилжилт хөдөлгөөнийг хянах, бөхөн хамгаалахад хүчээ нэгтгэх нь хэрхэн чухал болохыг харуулна.

## ОХУ-ын ханын үзэсгэлэн 2016 - эрхэм зорилго биелэгдлээ!

*Айгуль Айтбаева, Евгения Самтанова ба Рори МакКенн Яшкул Олон талт гимназ, [aigul-0889@mail.ru](mailto:aigul-0889@mail.ru)*

*Тавдугаар сарын амралтын өдрүүдэд Халимагийн БНУ-ын Элистагаас 90 км-ийн зайд орших Яшкуль сургууль дээр хээрийн зэрлэг ан амьтны талаарх ханын зурагны үзэсгэлэн ёслол төгөлдөр нээгдсэн. Энэ шинэ хандлага нь 2014-15 онд анх Узбекистан, Казакстанд хийгдэж байсан. Энэ жил, профессор Ю. Н. Арилов болон Бөхөн хамгаалах холбоо Халимагт хэрэгжүүлэх санаачилгыг дэмжин тусалсан юм. Уг сургуульд ОХУ-ын нэг гавъяат багш А. Самтанова тэргүүтэй (Амьд өв) хээрийн зэрлэг амьтдын клуб зохион байгуулсан. Их Британи, Сейшелийн Арлууд, Австрали, Оман, Японд үзэсгэлэнгээ гаргасан ханын зураач Рори МакКенн мөн хүрэлцэн ирсэн. Төслийн санаа нь багш нар, хүүхэд, эцэг эхийн оролцоотойгоор ханын зураг урлах замаар бөхөнгийн талаарх хүмүүсийн хандлагыг өөрчлөх байсан юм. Төслийг Бөхөн хамгаалах холбоо, Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ (WCN), ОХУ-ын ДБХС дэмжсэн байна.*

Яшкулийн хүмүүс 2016 оны 4 сарын 18-ны өглөө Халимагт Британийн зэрлэг ан амьтдын зураач Рори МакКенн ирэхийг тэсч ядан хүлээж байсан юм. Яшкул дүүргийн Засаг дарга, ноён

Хаглышев хүлээсэн хүмүүсийн дунд байсан. Рори мэндчилгээндээ төслийн ач холбогдлыг онцлон тэмдэглэж, энэ нь зэрлэг ан амьтад хүмүүсийн хандлагыг сайжруулахад туслах болно гэж хэлсэн.



### Шинэ мэдээ (үргэлжлэл)

Хүлээн авах ёслол дээр Роритой сургуулийн бүх сурагчид болон тэдний багш нар мэндчилж, Халимагийн уламжлалын дагуу цагаан хадак (торгон ороолт) түүнд бэлэглэсэн. Хүлээн авах ажиллагаа нөхөрсөг болж өнгөрсөн бөгөөд тэр үед Рори бидэнд өөрийнхөө тухай, гэр бүлийнхээ тухай, дэлхийн янз бүрийн улс оронд гүйцэтгэж байсан олон тооны төслүүдийнхээ тухай ярьж өгсөн. Сурагчдад экологийн боловсролын ололт амжилтын тухай Рори хэлсэн. Үндсэндээ зураачийн ирэхээс өмнөх 12 хоногийн турш хээрийн гөрөөс зургийн уралдаанд түрүүлсэн янз бүрийн насны хүмүүс ханын зураг зурах ажлыг сурагчдын идэвхтэй оролцоотойгоор хийж эхэлсэн. Завсарлагаа бүрт Рори олон хүн хүрээлсэн газарт очиж, тэр сайхан хээрийн амьтан, ургамлын зургийг хүүхдүүд хэрхэн болгоомжтой зурсаныг анхааралтай харж байсан. Тэдний хооронд зарим хэлний бэрхшээл байсан хэдий ч хүүхдүүдэд Рори олон асуулт тавьж, очсон нутаг орныхоо

ургамал, амьтны аймгийн тухай аль болох их зүйл сурч мэдэхийг эрмэлзэж байв. Яшкуль хотод амьдарч байгаа бусад хүмүүс мөн ирж ханын зураг үзэж сонирхонгоо Рорид янз бүрийн бэлэг өгчээ. Гаряевын гэр бүл Халимагийн нэрт зураач Папаевын зургийг дурсгасан бол Нокаев болон Насакаевын гэр бүл зураачид уламжлалт халимаг маягаар чимэглэсэн халимаг тоглоом болон шаазан аяга өгсөн.

Рори зургийн уралдаанд оролцсон 60 хүүхдэд уран зургийн хичээлийг заасан. Тэд амьтан зурах болон цоолтуур ашиглан ил захидал хийж сурсан. Залуу оюутнуудаас бүрдсэн мастер ангийн хүүхдүүд маш их сонирхолтойгоор Роригийн зааврыг сонсож, түүний хөдөлгөөн бүрийг дагуулан харж байв. Үүний дараа бөхөнгийн янзагаар чимэглэсэн зураг бүхий ангид орсон. Рори нь англи хэлний хичээлд оролцож, хөвгүүдтэй ярилцсан. Тал хээрийн зэрлэг амьтны клубын гишүүд өөрсдийн уулзалтын



Рори МкКанн болон түүний хээрийн зэрлэг амьтдыг харуулсан гайхалтай ханын зураг. © Айгуль Айтбаева.



Рори “Амьд өв” талын клубын гишүүдийн хамт. © Айгуль Айтбаева.

нэгэнд Рориг урьж, тэрээр клубын үйл ажиллагааны талаар танилцуулга авч, гитар тоглож, гайхалтай дуу дуулж байв. Клубын гишүүд мөн англи хэл дээр дуулсан. Уулзалтын төгсгөлд сурагчид Рориг клубынхээ гишүүн болгож, клубын билэгдэл болох тэмдэг болон Халимагийн уламжлалт шатрын багц түүнд бэлэглэсэн.

4 сарын 29-нд Хээрийн амьд өв нэртэй ханын зургийн уралдаанд зориулсан ёслолд багш нар, сурагчид, тэдний эцэг эх болон бусад зочид оролцсон. Багш, сурагчид хэлсэн үгэндээ ханын зураг нь бөхөн хамгаалалд өөр өөр орны хүмүүсийн нэгдлийн билэг тэмдэг болж байгаа бөгөөд энэ нь зөвхөн түүний гоо үзэсгэлэн, өвөрмөц байдлаар хүмүүст аз жаргал бэлэглэх бус, харин зэрлэг ан амьтдыг хамгаалах шаардлага байгааг тэдэнд сануулах гол зорилготой гэж онцлон тэмдэглэж байв.

Хоёр долоо хоногийн нэг өдөр шиг нисэн өнгөрч, тосгоны нэгэн дотны найз болсон «бидний» Рори явах үед үүнийг хэн ч хүссэнгүй. Рори бүгд найрамдах улсын бүх хүмүүст залуу үеийн зэрлэг ан амьтанд хандах эерэг хандлагыг дэмжин туслах,

олон жилийн турш хадгалагдах сайхан бэлэг өгсөн нь эргэлзээгүй.

Эцэст нь хэлэхэд, бид Рорид болон Халимагт энэ гайхалтай зураачийн айлчлалыг зохион байгуулсан бүх хүмүүст, төдийгүй энэ чухал ач холбогдолтой төсөлд оролцсон багш, сургуулийн сурагчдад асар их талархал илэрхийлэхийг хүсч байна. Ханын үзэсгэлэнгийн тухай эндээс олж болно: <https://www.youtube.com/watch?v=jAsDNFuNtdQ>. Мөн доорх хаягаар үзэж болно: <https://rg.ru/2016/07/12/reg-ufo/hudozhnik-iz-anglii-narisoval-fresku-s-sajgakami-v-kalmykii.html>.

.....  
**Рори МсКанн, зэрлэг амьтдын зураач,**  
[rori.mccann84@gmail.com](mailto:rori.mccann84@gmail.com)

Өнгөрсөн 4 жилийн турш би зэрлэг ан амьтныг сонирхолтой хүмүүст урам зориг өгөхийн тулд урлагийг ашиглах тал анхаарч, ханын уран бүтээлчээр ажиллаж байна. Ямар ч эргэлзээгүйгээр, Узбекистанд мөн Казахстанд, ОХУ-д Бөхөн хамгаалах холбоотой (SCA) хамтран хамгийн сэтгэл хөдөлгөм, сайхан ажил



### Шинэ мэдээ (үргэлжлэл)



Мастер ангийн хамгийн залуу оюутан.  
© Айгуль Айтбаева.

хийсэн нь миний сэтгэлийг өнөөдрийг хүртэл хөдөлгөж байна. Тухайн тохиолдол бүрт, би бөхөн аюул занал дор байгаа улс руу аялж байсан. Зураач миний эрхэм зорилго нь орон нутгийн амьтан, ургамал хамгаалахын ач холбогдолыг ойлгуулах зорилгоор Бөхөн хамгаалах нийгэмлэгийн хийж байгаа ажилд хүн бүрийн татан оролцуулж асар том ханын уран бүтээл туурвих явдал юм.

Энэ оны дөрөвдүгээр сард би ОХУ-ын баруун өмнөд хэсэг, Астрахан руу онгоцоор ниссэн. Би Яшкуль тосгоноос намайг тосч авахаар ирсэн Юрий Арилов (их сургуулийн профессор, БХХ-ны туслах) болон түүний хадам хүүтэй 4 цагт уулзан танилцаж, үүнээс хойших 2 долоо хоног өөрийн гэртээ байгаа юм шиг тэднийд байрласан. Ямар нэгэн зураг зурж эхлэхийн өмнө би орчуулагчийн (Анатолий) хамт өөрийн ажиллах орон нутгийн сургуультай танилцан, тосгоны дарга болох нүдэнд дулаахан хүнтэй уулзсан.

Дараагийн өдөр нь хонгор зул цэцэглэж байсан хаврын улирлыг санагдуулам ахлах ангийн сурагчдын тоглолтыг үзэхээр сургуульд зочилсон. Энэ нь яагаад намайг тэнд байгааг, Бөхөн хамгаалах нийгэмлэг ямар чухал болох талаар надад тодорхой

тайлбар хэлэх, мэдэх боломж өгсөн. Ингээд зураг эхлэхэд бэлэн болж, хүүхдүүдийн сониуч зан ба тэднийг соронзон мэт татах зүйл тийм удаан хүлээлгээгүй. Тэр ч байтугай зүгээр л цагаан будгаар ханыг будахад «уупс» болон «аах» гэсэн алмайрсан уулга алдалт олон байсан. Өдөр бүр өнгөрөх тусам, илүү олон сурагчид өөрсдийн завсарлагааны үеэр, сургуулиа тарсаны дараа үзэхээр, асуулт асуухаар ирдэг байсан. Нэгэнтээ бөхөн хэрхэн хэцүү байдалд байгаа болон хамгаалах талаар юу хийх шаардлагатай байгаа талаарх хэлэлцүүлэгээс авсан санаагаар ханан дээр хэд хэдэн бөхөнг зурсан. Намайг ядарсан үед багш нарын нэг нь «энэ нь Буддын шашны арга юм» хэмээн надад шүүс, шоколад авчирсан. Энэ нь надад би магадгүй Буддын шашинд орсон юм шиг харагдсан байх гэж бодогдсон.

Миний айлчлалын сүүлээр ойролцоох байгалийн нөөц газарт зочилж, байгаль дээрх бөхөнг харсан нь гайхалтай таашаал байв. Бид бас өвөгт тогоруу, тоодог, Европ зурам (жигжигхэн газрын хэрэм), мөн бидэнд гайхалтай зүйл харуулсан нөхөрсөг хос тэмээ харсан! Би буцаж явахдаа хээрийн амьдрах орчин, ан амьтны бүрэн гоо сайхныг бүрэн илэрхийлэх, шинэчлэх хүсэл тээн ханын уран бүтээлдээ эргэн ирсэн. Сүүлийн хэдэн өдрүүдэд өөрсдөө ханын зураг зурахаар мэрийж буй ахлах ангийн хүүхдүүд, мэргэжлийн ангийнханд ханын зурагнуудын тухай ярьж бид илүү үр дүнтэй зүйлсийг хийсэн. Энэхүү оролцоо нь бүх зүйлээс илүүтэйгээр байгаль орчныг үнэлэх, магадгүй тэд хожим нь амьдралдаа тэдний ажил мэргэжил, амьдралын хэв маягт нь юу хийх талаар сурагчдыг урамшуулах болно гэдэгт би итгэлтэй байна.

Ийнхүү зураг зурж, юм ярилцан, инээлдэж, шоколад идэн, тэмээтэй тааралдаж, бөхөн харсан 2 долоо



хоногийн дараа ханын зураг маань дууссан. Сургуулийн сурагчид, ажилтан, иргэд оролцсон нээлтийн ёслол зохион байгуулсан. Олон бэлэг солилцож, олон хүмүүстэй салах ёс гүйцэтгэсэн. Миний гарыг зөөлөн цэвэрлэж буй ажилтнаас эхлээд эелдэгээр ярих даргатай хүртэл сэтгэл зүрхнээсээ салах ёс гүйцэтгэсэн. Хэдийгээр би үг ойлгож чадахгүй мэдээж хэрэг ч үзэл санаа минь бол тодорхой байсан!

Донор байгууллагууд, миний ажилд итгэсэн Е.Ж Милнер-Гулланд болон Карлин Самуел, мөн Яшкуль сургууль, Анатолий, тав тухтайгаар хүлээн авсан



Халимаг гэр бүлийн хамт.  
© Айгуль Айтбаева.

Яшкуль тосгоны бүх хүмүүст баярласан талархсанаа илэрхийлж байна.



Амьд өв хээрийн зэрлэг амьтдын клубын гишүүд Роригийн хамт. © Айгуль Айтбаева.

## Шинэ мэдээ (үргэлжлэл)

### ОХУ, Узбекистан, Казахстан, Монголын алслагдсан орон нутгийн хүмүүс

*Бөхөн хамгаалах өдрийг тэмдэглэлээ.*

*Казахстан, ОХУ, Узбекистан, Монгол улсад 2011 оноос эхлэн Бөхөн хамгаалах өдрийг тэмдэглэж байна. 2016 оны бөхөнгийн өдөрт Монголоос залуу судлаачид оролцсон. Энэхүү баяр нь бөхөнгийн тархац нутгийн хүрээнд тэмдэглэдэг, төллөх хугацаанд хийгддэг үйл ажиллагаа юм. Гол зорилго нь хүүхдийн экологийн соёл, үзэл баримтлалыг төлөвшүүлэх, зэрлэг ан амьтдын хамгааллын асуудалд насанд хүрэгчдийн анхаарлыг татах, тал хээрийн экосистемийн мэдлэгийг нэмэгдүүлэх, хүн бүрийг хамгаалалд оролцуулах зэрэг юм.*

## ОХУ

*Евгения Самтанова ба Айгуль Айтбаева Яшкулийн Олон талт гимназ, [aigul-0889@mail.ru](mailto:aigul-0889@mail.ru)*

ОХУ-д бөхөнгийн өдрийн анхдагч, Яшкулийн Олон талт гимназ нь 2016 онд бөхөн хамгааллын чиглэлээр цуврал үйл ажиллагааг зохион байгуулсан. Бөхөнгийн өдрийн өмнөхөн тэд хүүхдүүдэд бөхөн хамгааллын ач холбогдлыг ойлгуулах, зэрлэг амьтдыг хамгаалах үйл ажиллагааг нэмэгдүүлэх, зэрлэг ан амьтдын хувьд шаардлагатай тусламж, дэмжлэгийг үзүүлэх зорилготой Хээрийн гөрөөс урлагийн уралдааныг зарласан. Бүх насны бүлгийн жаран сургуулийн хүүхдүүдэд тэмцээнд оролцсон гэрчилгээ, ялагчид ханын уран бүтээл хийх төслийн тодорхой хэсгийг зурах боломжийг олгосон байна (дээр дурдсаныг харна уу).

«Амьд өв» клубын гишүүд сургуулийн сурагчид болон зочдод зориулсан жижиг концерт зохион байгууллаа. Экологийн фэнүүд, жүжигчдийн баг, клубын гишүүд хамтран шинэ, сонирхолтой хөтөлбөр үзүүлсэн. Яшкуль сургуулийн сурагчид, багш нар нь тосгоны оршин суугчдад буяны концерт тоглосон. Концертоос олсон бүх мөнгийг тус тосгонд амьдрах олон хүүхэдтэй гэр бүлийн ээж, хүүхдэд нь



Экологийн сурталчилгааны баг “Экос” болон театрын “Бөхөн” бүлэг. © Айгуль Айтбаева

эмнэлгийн эмчилгээний мөнгө болгон өгсөн.

Үүнээс гадна, сургууль дээр Хээрийн өдөр гэж нэрлэгдэх үйл ажиллагааг зохион байгуулж, Хулхута, Молодежный, Яшкул, Черные Земли дүүргийн сургуулиудаас залуу байгаль хамгаалагчдыг, Черные Земли БНГ-аас судлаачид, Москва, Санкт-Петербург, Казань, Королеваас зочдыг урьсан. Экологийн тоглоом тоглоцгоосон. Үүний дараа, Зэрлэг амьтан хамгаалах төвийн биологич, зураач, шинжээч, доктор А. Олешенко зэрлэг амьтан зурах талаар мастер ангийн хүүхдүүдэд ярьж өгсөн. Сурагчид мөн хээрийн ургамал, амьтны аймгийн тухай гэрэл зургийн үзэсгэлэнд оролцсон байна.



## Узбекистан

*Наталья Шивалдова, Елена Быкова, Экомактаб, Бөхөн хамгаалах нийгэмлэг, [ebykova67@mail.ru](mailto:ebykova67@mail.ru)*

Уламжлал ёсоор 2016 оны 5 сарын эхээр Бөхөнгийн өдрийг Узбекистанд тэмдэглэн өнгөрүүлсэн. «Уламжлалт» гэдэг нь «уйтгартай» гэсэн үг биш юм. Бөхөнгийн өдөр энэ удаад Каракалпакистанд завгүй өрнөж байсан юм. Бүх насны хүмүүс, туршлагатай хөгшчүүлээс (ахлагч) эхлээд залуус, хүүхдүүд хүртэл оролцсон. Энэ жил Кырк Кыз тосгоны ойролцоох Уз-KOR хийн химийн компанийн ажилчид бөхөн хамгаалагчдын эгнээнд нэгдэн орсон байна. Тэд заг тарих, газар нутгийг нөхөн сэргээх ажлыг хийн Бөхөнгийн өдрийг тэмдэглэсэн. Тэд мөн Устюртын тал дээр бөхөн, биологийн төрөл зүйлийг хамгаалах талаар бага хурал зохион байгууллаа. Каракалпакистаны БНУ-ын Байгаль хамгаалах зөвлөл, Бүгд Найрамдах Узбекистан улсын Шинжлэх Ухааны Академи, Узбекистаны Экологийн хөдөлгөөн болон Бөхөн хамгаалах холбоо, түүнчлэн Кырк Кыз тосгоны хүмүүс оролцож, зэрлэг ан амьтан хамгаалах талаар ярилцаж байв.

Бөхөнгийн өдрийн өмнө хөл бөмбөгийн тоглолтын цуврал тоглолт Жаслык тосгонд болж, цэрэг, цагдаа, орон нутгийн аж ахуйн нэгжийн ажилтнууд, ахлах сургуулийн сурагчид өрсөлдсөн. Бөхөнгийн цомыг 54-р сургуулийн хүүхэд, багш нар хүртсэн юм. Хөл бөмбөгийн цом бөхөн хамгаалалд зориулсан спортын үйл явдлын цувралыг нээсэн. Насанд хүрэгчдийн хүндийн өргөлт болон гар барилдааны шилдэгээр хэн хамгийн сайн байсныг олж мэдэх хүсэлтэй байлаа. Аль хэдийн уламжлал болсон Экологийн галт тэрэг Жаслык болон Каракалпакистанд амжилттай зохион байгуулагдсан. Өөр өөр өртөөнөөс «галт тэргийг өөрчлөн» хүүхдүүд экологи, гадаад



“Бөхөнгийн цом” хөл бөмбөгийн тэмцээний өмнөх захиа даалгавар. © Елена Быкова

хэл, урлаг, спортын мэдлэгээ сорьсон. Ердийнх шигээ үзэгчид эртний уламжлал, тэдний уугуул нутаг, спортын уралдаан, «Нүүдэллэж буй бөхөн» нийтийн тоглоом, богино тоглолтыг хамгийн их сонирхож байсан. Жаслыкын цэцэрлэгийн хүүхдүүд өөрсдийн Бөхөнгийн өдрийг зохион байгуулж, Тал хээрийн ариун үлгэрүүд, бөхөнгийн янзаганы тухай хөдөлгөөнт түүхийг үзсэн.

Жаслык тосгоны бараг бүх хүн Бөхөнгийн өдрийн оройн шоу үзэхээр ирэв. Хүүхдийн тоглолт насанд хүрэгчдийнхээс тусдаа болж, шагналын ёслолоор өндөрлөсөн. Харанхуй болсон хойно үзэгчид «Устюртын тал нутгийн бөхөн» баримтат кино үзсэн. Тосгоны оршин суугчдын оролцоо, Бөхөн хамгаалах нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр Узбекийн баримтат кино үйлдвэрлэгчид “Амьд явах эрх” кино бүтээсэн. Энэ кино нь Олон улсын экологийн 20-р кино наадамд оролцон шагнал хүртсэн байна <http://ecofest-ugra.ru/ru/o-festivale/novosti/634>.

Хүүхэлдэйн театрынхан энэ жилийн Бөхөнгийн өдөрт зориулан цоо шинэ уран бүтээл бэлтгэсэн. Жаслык тосгоны



## Шинэ мэдээ (үргэлжлэл)



Сургуулийн хүүхдүүд хүүхэлдэй болон гоёл чимэглэлийг өөрсдөө хийж сурцаав.

«Акбокен» (Saiga), Нукус тосгоны «Надежда» (Найдвар) Хээрийн зэрлэг амьтдын клубын гишүүд Александра Заславскаягийн мэргэжлийн ангийнханы зааж өгсөний дагуу мини тоглолт бэлтгэж, өөрсдөө хүүхэлдэй, чимэглэл хийж сурсан. Хэд хэдэн бэлтгэлийн дараа хүүхдүүд сайн, муу зүйлс, хайр, анхаарал халамжийн тухай түүхүүдийг ярьж буй жинхэнэ жүжигчид болон хувирсан. Жаслыкаас ирсэн

хүүхдүүд эко-цэцэрлэгийн ханыг “Өөрийн тэмдэгийг үлдээ» гэсэн нэртэйгээр бөхөнгийн амьдралыг харуулан будаж экологийн үйл явдалд оролцжээ. «Баялаг, олон төрлийн зэрлэг амьтдыг үнэн хэрэгтээ бид бий болгохоор хичээж байна!» гэж онцолж байв. Энэ бүх үйл явдлыг насанд хүрэгчид идэвхтэй дэмжиж байгааг харах таатай байсан.



“Тудей” Хийн шахалтын станцийн ивээлд байдаг цэцэрлэгийн хүүхдүүд багш нарын хамт өөрсдийн “Бөхөнгийн өдөр” зохтон байгуулав. © Александр Есипов

## Казахстан

*Мухит Суммубаев, КБТЗХН, [mukhit.suttibayev@acbk.kz](mailto:mukhit.suttibayev@acbk.kz)*

Энэ оны 4 сарын сүүл, 5 сарын эхээр Казахстанд Бөхөнгийн өдрийг тэмдэглэлээ. Энэхүү баяр баясгалантай наадам тус улсад аль хэдийн уламжлал болсон бөгөөд Амьтан, ургамлыг хамгаалах олон улсын нийгэмлэг, КБТЗХН-тэй хамтран байгуулсан Шалкар дүүргийн Актобе аймгийн таван сургуулийн Бөхөнгийн найзууд клуб, түүнчлэн Бөхөн хамгаалах нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр 2014 онд байгуулагдсан Зүүн Казахстан мужийн Нурсай, Казтал дүүргийн Тал хээрийн амьтдыг хамгаалах клубууд оролцсон Акбокен сүлжээ зохион байгууллаа.

Бөхөнгийн өдөр Актобе тосгонд бүтэн өдөр үргэлжилсэн. Бүх насны сурагчид уралдаан, тоглоом, концерт болон бөхөнгийн тухай кино зэрэг мэдээллийн үйл ажиллагаанд сэтгэл хөдлөлтэйгээр оролцлоо. Үйл ажиллагааны төгсгөлд зэрлэг ан амьтдын талаар гүн мэдлэгтэй, хамгийн идэвхтэй оюутнууд диплом, талархлаар шагнуулсан.

Бөхөнгийн өдөр Төв Казахстанд Коргалзын БНГ-ын жуулчдын төвд үргэлжилсэн. КБТЗХН Бөхөн хамгаалах холбоотой хамтран Дружба болон Коргалзын тосгоны сургуулийн хүүхдүүдэд зориулсан сургуулийн кэмп зохион байгууллаа. Энэ нь



Хүүхдүүд бөхөнгийн тухай хүүхэлдэйн кино үзэж сонирхов. © АСБ

Бетпақдалагийн бөхөнгийн популяцийн тархац нутагт зохион байгуулсан бөхөнд зориулсан хүүхдийн үйл ажиллагааны анхны тохиолдол юм. Хэдийгээр зуны амралт байсан ч аль аль сургуулиас нийтдээ 100 гаруй залуу, сурагчид оролцсон байна. Хүүхдүүд тоглоом тоглож, бөхөнгийн тухай хүүхэлдэйн кино үзэн, зураг зурах тэмцээнд өөрсдийн ур чадвараа харуулсан бөгөөд зэрлэг ан амьтдын талаарх мэдлэгээ хуваалцсан. Хамгийн их урам зоригтой сурагчдад футволк, талархал, үнэмлэх, Бөхөнгийн комик, захидал өгсөн.

Бид хүүхдүүдэд экологийн боловсрол олгох талаар идэвхтэй ажиллаж, байгаль хамгаалах санаачлагыг дэмжиж байгаа багш нарт маш их талархаж байна.



### Шинэ мэдээ (үргэлжлэл)

#### Монгол

Буяна Чимэддорж, ДБХС, Монгол дахь хөтөлбөрийн газар, [chimeddorj@wwf.mn](mailto:chimeddorj@wwf.mn)



“Нэг өдөр байгаль хамгаалагч болъё” үйл ажиллагаанд оролцсон сурагчид.  
© ДБХС-Монгол

Алтай-Соёны экобүсийн унаган, ховордсон амьтан болох монгол бөхөнгийн хамгааллыг хүүхдүүд өргөнөөр дэмжин оролцдог. Гэрийн малтай бэлчээрийн өрсөлдөөнд ордог учир зарим нутгийн иргэд бөхөнд дургүй байдаг. Тиймээс хүүхдүүд хамгийн чухал зорилтот бүлгийн нэг бөгөөд тэд олон нийтэд өөрсдийн мессежээ илгээх ач холбогдолтой юм. «Нэг өдөр байгаль хамгаалагч болъё» нэртэй шинэ санаачлагыг Сингапур дахь ДБХС-ийн хөтөлбөрийн газар, Аниргүй сан дэмжин ажиллаж, бөхөн хамгаалалд бөхөн хамгаалагч, хүүхдийн эко клуб гишүүд хамтдаа ажиллахыг дэмжсэн.

Энэ санаачлага нь «Монгол бөхөнгийн өдөр»-ийн нэг хэсэг бөгөөд Говь-Алтай, Ховд аймгийн бөхөн тархсан сумдын нутагт 2016 оны 4 сарын 15-22 хүртэл долоо хоногийн турш үргэлжилсэн. Энэ долоо хоногийн турш 1000 гаруй хүүхдийг хамруулан олон үйл ажиллагаа, тухайлбал «Бөхөнг хэн хамгийн сайн мэдэх вэ?» асуулт хариултын уралдаан, зургийн уралдаан зохион байгуулсан. Хүүхдийн клубээс зохион байгуулсан дугуй ширээний ярилцлагыг бөхөнд учирч буй аюул занал, сурагчид хэрхэн түүнийг хамгаалахад хувь нэмрээ оруулах боломжтой зэрэг чухал асуудлыг хөндөн ярилцсан. Зарим

эко клуб нутгийн иргэд болон бусад оролцогч талуудыг хамруулан мод тарих арга хэмжээг зохион байгуулсан байна. Хүүхдүүдийн үйл ажиллагаа, мэдээлэл солилцох боломжийг бий болгосон Facebook групп нээсэн.

«Нэг өдөр байгаль хамгаалагч болъё» гэсэн үйл ажиллагаа хүүхэд, байгаль хамгаалагч, цаг уурч, малчдыг хамруулан бөхөнгийн амьдрах орчинтой танилцах аяллаар эхэлсэн. Цаг уурч бүс нутгийн уур амьсгал, бөхөн хэрхэн уур амьсгалын өөрчлөлтэнд хир эмзэг байж болох талаар мэдээлэл өгсөн. Байгаль хамгаалагч хүүхдүүдэд байгаль хамгаалагч байхын ач холбогдлыг ойлгуулж, бөхөнг хэрхэн хянадаг талаар ярьж өгөн, гэрийн мал бөхөнгийн амьдрах орчныг хэрхэн өөрчилж байгаа болон GPS ашиглах талаар заан өгч энэ өдрийн гол баатар байлаа. Говь-Алтай аймгийн Төгрөг сумын бөхөн хамгаалагч Батзаяагийн хүү сургуулийн амралтын үеэр аавынхаа хамт популяцийн үнэлгээ, эргүүл хийхэд оролцсон талаар өөрийн туршлагаа хуваалцсан юм.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар ховордсон



Байгаль хамгаалагч хүүхдүүдэд GPS ашиглахыг зааж байгаа нь. © ДБХС-Монгол



Монгол бөхөнгийн хамгааллын асуудалд хүүхдүүдийн эко клубын оролцоо, хувь нэмрийг үнэлдэг гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй юм. Оролцогч талуудын хамтарсан

чармайлт ачаар бөхөнгийн популяци 5000-аас 14,000 болж өссөн бөгөөд сүүлийн арав гаруй жилийн хугацаанд түүний амьдрах орчин 13% -иар тэлжээ.

## Хүүхдэд зориулсан боловсролын кемп: хүүхдийн байгаль хамгааллын хандлагыг дэмжих нь

**Казахстан: Бөхөнгийн найзууд клубийн анхны боловсролын кемп**

*Алёна Кривошеева, КБТЗХН, [alyona.krivosheeva@acbk.kz](mailto:alyona.krivosheeva@acbk.kz)*

Сүүлийн хэдэн жилийн турш Тал хээрийн экологийн клубууд Казахстаны янз бүрийн бүс нутаг дахь сургуулиудад бөхөн хамгаалах талаар анхаарч, орон нутгийн хүүхдүүдэд экологийн боловсрол олгох зорилгоор идэвхтэй ажиллаж байна. Одоогоор Устюртын бөхөнгийн популяци хамгийн жижиг, аюулд ойрхон байгаа бөгөөд орон нутгийн иргэдэд хулгайн ангийн талаар сурталчилгаа хийх болон тэдэнд яагаад бөхөнг хамгаалах шаардлагатайг харуулах нь чухал ач холбогдолтой юм. Тиймээс бид Устюртын тал дээр тосгонд амьдардаг хүүхдүүдийн хээрийн зуны кемп зохион байгуулах шийдвэр гаргасан.

Шалкар хотын болон Аккятым, Бякадам, Бозой, Шалкар тосгонд байх Бөхөнгийн найзууд клубээс 11-14 хүртэлх насны арван таван хүүхэд уригдсан уг хээрийн кемпийг Амьтан ургамал хамгаалах олон улсын нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр (КБТЗХН хамтран зохион байгуулсан) зохион байгуулсан. Сурагчид 6 сарын 27-ноос 7 сарын 1 хүртэлх хугацаанд Иргиз Тургай БНГ дотор орших Малайдар нуурын ойролцоо өнгөрөөсөн. Хүүхдүүд бүс нутгийн ургамал, амьтдын талаар мэдэж авсан. Уг үйл ажиллагааг зохион байгуулагчид хүүхдэд экологийн соёлыг хөгжүүлэх, цаашид Бөхөнгийн найзууд

клубын гишүүдтэй нэгтгэж, хамтран үйл ажиллагаа явуулах чиглэлээр ажилласан. Мөн Устюртын тал дээр экологийн клубын удирдагчид цугларч, ирээдүйн чиглэлийг хэлэлцэж, ажлын хөтөлбөр боловсруулах, түүнчлэн туршлага хуваалцах, тэдний ололт амжилтыг тэмдэглэсэн. Хүүхдүүд бие биенээ мэдэх, санал солилцох, найз нөхөдтэй болохдоо маш хурдан байсан.

Кемпийн хөтөлбөрт тоглоом, сургалт, хэлэлцүүлэг, кино, дадлагын ажил багтсан байв. Эхний өдөр хүүхдүүд Иргиз Тургай БНГ, амьтны аймаг, бүс нутгийн түүх, соёлын үйл явдлын талаар мэдээлэл авсан. Дараагийн өдөр тэд ургамлын хатаадас хийх, БНГ-т тархсан шавжийн тухай олж мэдсэн. Тэд шувуу ажиглах ажилд бүтэн өдөр зориулсан. Кемп нь нууртай ойрхон учир шувуу ажиглах хамгийн боломжтой орчин юм. Хүүхдүүд байгаль дээрээ өөр өөр зүйл шувууд ямархуу зан авир гаргадгийг ажиглан харж, харсан зүйлээ тэмдэглэж байв. Өдрийн төгсгөлд тэд 16 зүйлд хамаарах 232 шувуу



Зуны хээрийн сургалтын залуу оролцогч. © КБТЗХН

## Шинэ мэдээ (үргэлжлэл)



Иргиз Тургай БНГ-т шувуу ажиглаж байгаа нь. © КБТЗХН

бүртгэснээс Улаан номонд орсон 2 зүйл бүртгэсэн (Хаан бүргэд, Борцгор хотон). Хамгийн сэтгэл хөдөлгөм зүйл нь хүүхдүүд хуаран руу буцах замд тохиолдсон. Хоёр янзагаа дагуулсан 3 эмэгчин бөхөн тэдний машины урд зам гаталж байсан. Өмнө нь бөхөнг хэзээ ч хараагүй сурагчид гайхаж, баяртай байсан; өмнө нь хээрийн гөрөөсний талаар маш их сонсож байсан бөхөнгөө харж тэдгээрийн хамгааллын талаар ярилцсан юм! Мөн нэг аялалын үеэр хүүхдүүд Жаманшын солирын тогоо руу очжээ. Түгээмэл тархсан таамаглал нь уг тогоо солирын (магадгүй бага гаригуудын эсвэл сүүлт од) уналтаас үүдсэн дэлбэрэлтээс үүсэн диаметр нь 200-400 м

байдаг явдал юм. Сүйрлийн дараахан тогоо нь 500 м-ийн гүнтэй байжээ.

Кемпт оролцсон бүх хүүхдэд футболка, малгай, боловсролын материал, бусад дурсгалын бэлэг бэлэглэсэн. Гэсэн хэдий ч, хамгийн чухал зүйл нь уг сургалтын уур амьсгал, харилцаа холбоо, практик хичээл, зэрлэг ан амьтдыг харсан нь тэдэнд арилшгүй сэтгэгдэл үлдээсэн гэж үзэж байна. Энэ туршлага ирээдүйд өөрсдийн



Оройн түүдэг галын эргэн тойронд. © КБТЗХН

уугуул нутгийн байгаль орчныг хамгаалахад үүрэг хариуцлагаа мэдрэхэд хүүхдүүдэд тусална гэдэгт бид итгэж байна.



Хөгжилтэй флэш. © КБТЗХН



Зуны хээрийн сургалтын залуу оролцогч. Хүүхдүүд шагнал гардуулах ёслолын дараа.

### Узбекистан: Залуу байгаль хамгаалагчдыг бэлтгэх сургалт

**Наталья Шивалдова, Экомактаб ТББ, [nshivaldova@mail.ru](mailto:nshivaldova@mail.ru)**

Каракалпакистан даяарх хээрийн клубээс ирсэн хүүхдүүд зуны амралтынхаа сүүлийн хэдэн долоо хоногт Бөхөнгийн зуны кемпд оролцон дараагийн хичээлийн жилд урам зоригийг олж авах, санал бодлоо хуваалцахаар Чаткал БНГ-аас холгүй орших үзэсгэлэнт хөндийд цугларсан байлаа. Уулын анхилуун ургамал, хөдөө нутгийн цэнгэг агаар, мөнгөрөн урсах уулын горхи, түүнчлэн амьтан, ургамлын баялаг зүйлийн бүрдэл, гайхамшигт уулын нуур нь хүүхдэд байгалиа хайрлах гүн гүнзгий сэтгэлийг өгч, олон шинэ зүйлийг тэдэнд нээн харуулж байв..

Хөтөлбөр нь маш олон зүйлээс бүрдэж байсан. Энэ жил аялал, хичээлүүд болон гаднах үйл ажиллагаа гэсэн сонголттой гурван хичээл багтсан байна. Татьяна Гритсинагийн хийсэн экологийн загварын хичээл дээр хүүхдүүд маш энгийн зүйлээр урлагийн бүтээл хийж болохыг сурсан бөгөөд хөвгүүд, охид уулын горхины жирийн хайрга ашиглаж сонирхолтой уран бүтээл хийж, голын өнгөлөг элсээр



Эко-зуслангийн нээлт. © Александр Есипов



Ууланд аялсан нь. © Наталья Шивалдова

гайхалтай зургийг зурсан. Тэдний бүтээлүүд уг сургалтын үзэсгэлэнд дэлгэгдсэн. «Экологийн театр»-ийн курс нь хүүхэлдэйн тоглолт хийснээр тэдний урлагийн авьяас чадвараа харуулах боломжийг олгосон юм. Александра Заславская жүжгийн анхны хувилбарыг бичихэд сурагчдад тусалсан. Хүүхэд бүр нь өөр өөрийн хувилбарыг санал болгож байсан бөгөөд тэдгээрийг нэгтгэн, ерөнхий түүхийн санааг гаргасан. Кемп зохион байгуулсан газар нь 2016 оны 6 сарын 22-нд нээгдсэн Каракалпакистаны шинэ Сайгачий БНГ-т байрлаж байсан. Хулгайн ангаас бөхөн хамгаалах нь чухал хичээл байсан. Сонирхолтой зан чанар, гайхамшигт хувирлууд, сайн муу хоёрын хоорондох ид шид, тэмцэлдээнийг харуулсан энэхүү жүжигчилсэн тоглолтын төгсгөл нь нөхөрлөл, сайн зүйлийг бүтээсэн нь үргэлж ялагч байсан. Экологийн театрын курсэд хүүхэлдэй урлах мастер хичээл мөн багтсан байсан. Тоглолтын гүйцэтгэл нь бидэнд экологийн хүүхэлдэйн театрын төрөл маш их боловсрол олгох, хүчирхэг зүйл болохыг илүү батлан харуулж байлаа.

Экологийн залуу сэтгүүлч гэсэн гурав дахь курсэд оролцогчид бусад бүх үйл ажиллагааг анхааралтай ажиглаж байсан. Бяцхан сэтгүүлчид түүх, хүмүүсийн ярилцлагыг хэрхэн бичиж, видео дүрс бичлэг, гэрэл зургийн тайлан гаргах зэрэг



### Шинэ мэдээ (үргэлжлэл)

үндсэн мэргэжилд анх удаа суралцсан. Үүний дараа тэд ханын сонины материал цуглуулах зэргээр өөрсдийн сэтгүүл зүйн үйл ажиллагаагаа эхэлсэн.

Ирэх хичээлийн жилийн туршид иймэрхүү үйл ажиллагаа зохион байгуулахад туслах учир Нүүдлийн зүйлүүдийг хамгаалах өдөр, Тусгай хамгаалалттай газар нутгийн өдөр болон Бөхөнгийн өдөр зэрэг экологийн боловсрол, шинэ ур чадвар, арга барил эзэмших бүхий л үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байсан. Хүүхдүүд кемп дээрээ Далайн вангийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлсэн нь экологийн наадмыг хэрхэн зохион байгуулахын сайн үлгэр жишээг үзүүлж, хүүхдүүдийн хувьд мартагдашгүй үйл явдал болсон. Гол сэдэв нь Арал тэнгисийн эмгэнэлт үйл явдал байсан юм. Далайн бурхан, усны хаан, бусад үлгэрийн тусалцаатайгаар сурагчид нуурыг аврах арга замыг олжээ. Сургалтын кемпийн өдөр бүр Биологийн төрөл зүйлийн өдөр, Байгаль хамгаалагч нарын өдөр, Цэвэр агаар, Эрүүл мэндийн өдөр, Усны өдөр, Найрамдлын өдөр гэх мэт тодорхой сэдэвтэй холбоотой байсан.

Зохион байгуулагчид үйл ажиллагааг сонирхолтой, сэтгэл хөдөлгөм байдлаар

энгийн хирнээ хялбархан ойлгож чадахуйц байдлаар хийсэн. «Экосистем», «Махчин амьтан болон тэдгээрийн золиос» гэсэн экологийн тоглоом үр дүнтэй байсан. Сан-Диего хотын амьтны хүрээлэнд болон Сафари Паркад болсон багш нарын сургалтын хөтөлбөрийн үеэр зохион байгуулагчид шинэ санаа, ур чадвар эзэмшиж сурсан нь үр дүнгээ өгсөн. Сан-Диего хотын амьтны хүрээлэнгийн хамт олон багш нарын чадварыг дээшлүүлэх, багшийн гарын авлага болон сурагчдад зориулсан «Бөхөн- хээр талын ариун сүнс» номыг хэвлэхэд тусалсан бөгөөд уг номны орос хувилбарыг хүсэлт гарган Бөхөн хамгаалах нийгэмлэгээс эсвэл <http://www.saigaresourcecentre.com> сайтаас авч болно.

Бөхөнгийн хүүхдийн кемпт өнгөрүүлсэн арван өдөр нисэх мэт өнгөрсөн. Хүүхдүүд, тэдний багш нар шинэ мэдээлэл, аз жаргалтай, мартагдашгүй сэтгэгдэл дүүрэн, хамгийн гол нь бөхөн хамгаалахад хувь нэмрээ оруулах тууштай хүсэлтэйгээр төрөлх тосгондоо эргэн ирсэн.

Энэхүү хүүхдийн кемп Узбекстанд хоёр дахь жилдээ зохиогдож байна. Бид тодорхой туршлага, арга барил хуримтлуулж, боловсролын шинэ хандлагыг боловсруулан, нийтлэг нэг зорилгын төлөө



Далай вангийн өдрийг тэмдэглэж байгаа нь. © Оля Есипова



«Сайгачий-2016» эко-зуслангийн оролцогчид. © Александр Есипов

нэгдсэн сонирхогч хүмүүсийн бүтээлч багийг байгуулсан байна. Экологийн сургалтыг бүс нутгийн судалгаа, экологийн «Баркамол Авлод» хүүхдийн төвийн (Бүгд Найрамдах Узбекистан Улсын Төрийн Боловсролын яам) оролцоо, «Экомактаб» экологийн нөөцийн төв, Бүгд Найрамдах

Узбекистан Улсын Шинжлэх Ухааны Академийн амьтан, Ургамлын удмын сангийн хүрээлэнгийн эрдэмтэд болон Оцон шувуу клуб, Канадын Дисней, Бөхөн хамгаалах холбооны дэмжлэгтэйгээр зохион байгуулсан.

## Хэвлэлийн мэдээ

**Казахстанд бөхөн хууль бусаар агнасан гэмт хэргийн шинжтэй 20 тохиолдол бүртгэгдлээ.**

Казахстаны Хөдөө аж ахуйн яамны Зэрлэг амьтан, ойн менежмент зөвлөлийн орлогч дарга Нариман Зунусов байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг



Ферганы агуулахад олдсон бөхөнгийн эвэр. © gazeta.uz

илрүүлэх, тэдгээрийг барихад тодорхой ахиц дэвшил гарч байгааг хэлэхдээ: 2014 онд бөхөн хууль бусаар агнасан 79 гэмт хэргийг илрүүлсэн бол 2015 онд 107 тохиолдлыг илрүүлэн 3000 гаруй эврийг хураан авчээ. 2016 он гарсаар 20 эрүүгийн хэргийг илрүүлж, 600 орчим бөхөнгийн эвэр хураагдсан байна. Холбогдох газар нэгжийн хөрөнгө оруулалт сайжирсаны улмаас бөхөн хамгаалалд томоохон ахиц дэвшил гарч байна. Энэ жил Охотзоопром шинэ бартаат замын тээврийн хэрэгслээр тоноглогдсон байна. Одоо тэд илүү их хурд буюу маневртайгаар хулгайн анчидтай тэмцэж чадна» гэжээ. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг доороос үзнэ үү.

[http://bnews.kz/ru/news/proisshestviya/s\\_nachala\\_goda\\_v\\_kazahstane\\_zavedeno\\_20\\_ugolovnih](http://bnews.kz/ru/news/proisshestviya/s_nachala_goda_v_kazahstane_zavedeno_20_ugolovnih)



## Хэвлэлийн мэдээ (үргэлжлэл)

[del za nezakonnij otstrel saigi-2016\\_05\\_04-1269907](#)

**Узбекистаны Фергана хотноо их хэмжээний бөхөнгийн эвэр, арьс хураагдав.**

Узбекистаны Фергана мужийн гаалийн байгууллагаас хийсэн мэдэгдэлд бөхөнгийн эвэр бүхий томоохон ачааг хил нэвтрүүлэхийг завдсан үйлдэл гарсаныг дурджээ. Ферганад үндэсний аюулгүй байдлын албаны гишүүд гаалийн ажилтнуудтай хамтран явуулсан ажиллагаагаар 468 бөхөнгийн эвэр, 72 эврийн хэсэг, 170 арьсыг илрүүлсэн байна. Эдгээр бүтээгдэхүүнийг Сох дүүрэгт оршин суугч этгээд хууль бусаар экспортлох гэж байжээ. Албаны тооцоогоор эдгээрийн үнэ цэнэ нь 148 сая сум (~ 46.879 ам.доллар)



юм. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.gazeta.uz/2016/07/14/saygak/> хаягаар үзнэ үү

### Хятадад бөхөнгийн эвэр хураагдлаа

Зургаан сар гаруйн мөрдөн байцаалтын дараа 2016 оны есдүгээр сарын эхээр Бээжин, Сычуан, Шинжаан тойргийн ойн цагдаагийн товчоо 1502,25 кг бөхөнгийн эвэр хурааж, 12 сэжигтнийг баривчилжээ. Хураагдсан эврийн зах зээлийн үнэ 320 сая юань (46,625,824 ам.доллар) юм. Энэ нь БНХАУ-ын баруун хойд мужид Урумчи хотод болон Юили хотуудад илэрсэн бөхөнгийн эврийн томоохон худалдан авалт юм. Эрх баригчид одоогоор энэхүү хэргийг судалж байна. Дэлгэрэнгүй мэдээлэл өгөх хараахан болоогүй байна.

<http://v.ifeng.com/news/society/201609/01cb9225-754b-11e6-86e6-002590c2aaeb.shtml>

## Өгүүлэл

**Баруун монголын бөхөнгийн тархалт ба шилжилт хөдөлгөөнд хүний суурьшил нөлөөлөх нь**

*Буянаа Чимэддорж<sup>1</sup>, Эрдэнэбаатар Сэргэлэн<sup>1</sup>, Баярбаатар Бүүвэйбаатар<sup>2</sup>*

*1- ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Улаанбаатар, Монгол, 2 - Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг, Монгол дахь төлөөлөгчдийн газар, Улаанбаатар, Монгол*

Монгол бөхөн (*Saiga tatarica borealis*) нь Монгол орны баруун хэсэгт Говь-Алтай, Ховд аймгийн нутагт тархсан. Энэ дэд зүйл нь ДБХХ-ний ангиллаар ховордож байгаа

ангилалд хамаарах бөгөөд ховордлын шалтгаан нь хэт агналт, гэрийн малтай бэлчээр, усаар давхцан шахагдах, хахир



## Өгүүлэл (үргэлжлэл)

хатуу өвлийн дараах ган гачиг болно. Гэсэн хэдий ч, сүүлийн хэдэн жилд хамгаалалт сайжирсан, таатай уур амьсгалын улмаас монгол бөхөнгийн популяци нэмэгдэж байна. 2014 онд хийгдсэн хамгийн сүүлийн үеийн популяцийн үнэлгээгээр тархац нутгийн хүрээнд ~ 15,000 тоо толгой байгааг тогтоосон.


Одоогийн байдлаар хөдөө орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах, зах зээл, боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх зорилготой Говь-Алтайгаас Ховд аймгийн чиглэлд 263 км урт хатуу хучилттай авто зам тавигдаж байна. Хүйсийн говийн замын хэсэг нь ерөнхийдөө бөхөнгийн амьдрах орчин дундуур үргэлжилнэ. Зам нь бөхөнгийн шилжилт хөдөлгөөнд саад учруулах, амьдрах орчны шууд ба шууд бусаар хуваан алдагдуулах, тэдгээрийн тархац нутагт хүрэх боломжийг нөхцөлдүүлсэнээр хулгайн ан нэмэгдүүлэх нөхцөл болдог гэж таамаглаж байна. Зөв хяналт байхгүйгээр хатуу хучилттай авто замын нөлөөллийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй төлөвлөж болохгүй. Бидний зорилго нь монгол бөхөнгийн тархац, шилжилт хөдөлгөөнийг сансрын телеметрийн аргаар тандан судалж, тэдгээрт хатуу хучилттай замаас үзүүлэх нөлөөг хянах хээрийн судалгаа байсан.

Бид 2015 оны 9 сарын 30-наас 10 сарын 2 хүртэлх хугацаанд (Зураг 1) Шаргын болон Хүйсийн говиос 8 бөхөн барьж хүзүүвчилсэн. Барьсан бөхөнд байршлыг 2 цаг тутамд илгээх тохируулга бүхий (Pinnacle Iridium Lite G5C 275F Sirtrack) сансрын дохиололтой хүзүүвч зүүсэн. 2016 оны 6 сар хүртэл бөхөн хүзүүвчилсэнээс хойш 10 сарын хугацаанд нийтдээ 22732 GPS солбилцол буюу (нэг бодгалиас ердөө 15 өдөр мэдээлэл авсаныг эс тооцвол) дунджаар амьтан бүрээс 3221 (хязгаар = 2.875 – 3.358) цэгэн мэдээлэл цуглуулсан билээ. Шаргын говьд баригдсан 4 амьтнаас

хүлээн авсан ойролцоогоор 7.006 цэгэн мэдээлэл нь (нийт мэдээллийн 69%) хүзүүвчний ажиллах хугацаанд (1-р зураг) Шарга БНГ дотор байсан. Бид Бергер нарын сансрын дохиололтой хүзүүвч ашиглан урьд нь тодорхойлсон коридороос (2008) гадна Шаргын болон Хүйсийн говийн салбар популяцийг холбодог шилжилт хөдөлгөөний өөр замыг тодорхойлсон.

Хоёр цагийн дотор хийсэн шилжилт хөдөлгөөний дундаж утга  $0.71 \pm SD 0.99$  км байсан (7 бодгалийн мэдээлэлд үндэслэв) ба хамгийн ихдээ 5 ба 14 км зайд шилжилт хөдөлгөөн хийсэн байна (Хүснэгт 1). Шилжилт хөдөлгөөний дундаж утга Хүйсийн говь ( $0.77$  км) болон Шаргын говьд ( $0.65$  км;  $t = -7.74$ ,  $p < 0.001$ ) хүзүүвчилсэн бөхөнд ялгаатай байсан. Судалгааны хугацаанд бөхөнгийн шилжилт хөдөлгөөн хийсэн нийт утга нь дунджаар  $2,300 \pm SD 436$  км (Хязгаар = 1,752 – 2,822) байв.

Бодгалиудын эзэмшил нутгийн хэмжээ бие биеэс 7 дахин ялгаатай байсан (хязгаар



Зураг 1. Шаргын болон Хүйсийн говиос хүзүүвчилсэн бөхөнгийн (n = 7) хийсэн шилжилт хөдөлгөөн

## Өгүүлэл (үргэлжлэл)

**Хүснэгт 1. Баруун Монголд хүзүүвчилсэн монгол бөхөнгийн мэдээлэл, 2015 оны 10 сараас 2016 оны 7 сар хүртэлх 10 сарын хугацаанд, 2 цаг тутамд хийсэн шилжилт хөдөлгөөний хурд (км), эзэмшил нутаг (MCP – Minimum Convex Polygon)**


Баригдсан газар	Хүзүүвч ID	Мэдээлэл өгсөн огноо	Хүлээн авсан мэдээлэл	Шилжилт хөдөлгөөний эрчим, Mean ± SD	100% MCP, км <sup>2</sup>
Шарга	62063790	09/30/15 - 10/15/15	182 *	0.98 ± 1.11	184
	62068770	09/30/15 - 07/06/16	3358	0.55 ± 0.73	1,115
	62670350	09/30/15 - 09/30/16	3357	0.79 ± 1.06	2,268
	62676340	09/30/15 - 05/28/16	2895	0.61 ± 0.88	2,967
Хүйс	62060790	10/01/15 - 07/06/16	3358	0.84 ± 1.16	7,81
	62673340	10/02/15 - 07/07/16	3356	0.79 ± 1.12	4,918
	62679330	10/02/15 - 07/07/16	3351	0.72 ± 0.99	2,611
	62679340	10/02/15 - 07/08/16	2875	0.68 ± 0.98	6,403

\* Уг бодгалиас ердөө 15 өдөр мэдээлэл авсан.

= 1,115 – 7,810 км<sup>2</sup>; дундаж = 4,013 км<sup>2</sup>; Хүснэгт 1). Хүйсийн говьд баригдсан бөхөнгийн эзэмшил нутгийн дундаж хэмжээ (5,436 км<sup>2</sup>) нь Шаргын говьд баригдсан бөхөнгийн эзэмшил нутгаас (2,117 км<sup>2</sup>) харьцангуй том байсан нь айл малын байршил багатай байдагтай холбоотой (Kruskall–Wallis test:  $H = 9.34$ ,  $p < 0.05$ ). Хүзүүвчилсэн бөхөнгүүдийн шилжилт хөдөлгөөний дундаж утга сараас хамааран өөрчлөгдөж байсан (One-way ANOVA:  $F = 25.37$ ,  $p < 0.001$ ) ба 2 сард хамгийн ойр, 2016 оны 6 сард хамгийн хол зайд шилжилт хөдөлгөөн хийжээ (Зураг 2). Бидний үр дүнгээр 5-9 сард Хүйсийн говьд зам барилгын ажил явагдаж байсантай холбоотойгоор замаас алс хол зайг сонгон бэлчиж байсан нь хүний суурьшлаас бөхөнгийн тархацад сөрөг нөлөө үзүүлж болохыг харуулж байна.

Бид бөхөнгийн шилжилт хөдөлгөөн, эзэмшил нутгийн хэмжээ, амьдрах орчны ашиглалтанд нөлөөлж болох хүчин зүйлүүдийг тооцоолон гаргахын тулд шилжилт хөдөлгөөний хэв маягийг улирал, хүрээлэн буй орчин болон хүний хүчин зүйлтэй холбоотой хувьсагчуудтай

хамааруулан анализ хийхээр төлөвлөж байна. Цаашдын мониторинг судалгааны үр өгөөж нь хүний суурьшил, ялангуяа хатуу хучилттай замаас шилжилт хөдөлгөөн, амьдрах орчны ашиглалт хоорондын жилийн өөрчлөлт ялгааг илүү сайн ойлгохын тулд наад зах нь хоёр жил дараалан илүү олон амьтдыг барьж хүзүүвчлэн, тэдгээрийн шилжилт хөдөлгөөнийг хянах ёстой.



Зураг 2. 2015 оны 10 сараас 2016 оны 6 сар хүртэлх хугацаанд Хүйсийн говьд тавигдаж байгаа хатуу хучилттай замаас бөхөнгийн байршил хүртэлх зай сараар өөрчлөгдөх онцлог

## Казахстанд 2016 онд хийгдсэн бөхөнгийн агаарын тооллогын үр дүн

**Штеффен Цутер, Альберт Салемгареев КБТЗХН, [steffen.zuther@acb.kz](mailto:steffen.zuther@acb.kz), [albert.salemgareev@acb.kz](mailto:albert.salemgareev@acb.kz)**

Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэгээс (КБТЗХН) 2016 оны 4 сарын 18-наас 5 сарын 3 хүртэлх хугацаанд тус улсын Бетпақдала, Урал болон Устюртын гурван бөхөнгийн популяцид жил бүр хийгддэг агаарын тооллого судалгаа явуулсан. Уг судалгааг Бүгд Найрамдах Казахстан улсын Хөдөө аж ахуйн яамны Ой, зэрлэг амьтан хорооны захиалгаар хийсэн бөгөөд Охотзоопрам болон Казавиапас хамтран хэрэгжүүлжээ. Агаарын тооллого, судалгаанд Алтын Дала БНГ, Иргиз Тургай Улсын БНГ болон Коргызлан БНГ зэрэг хамгаалалттай газар нутгийн судлаачид, бүс нутгийн ой, ангийн хэлтсийн ажилтнууд оролцсон.

Судалгааны дүнд Бүгд Найрамдах Казахстан улсын бөхөнгийн тоо толгой 2016 онд 108300 бодгаль, үүнээс 36.200 нь Бетпақдалагийн популяцид, 70.200 нь Уралын болон 1900 нь Устюртын популяцид тус тус тоологджээ.

Уг мэдээллээс харвал Уралын болон Устюртын популяцийн тоо хэмжээ өсөж байгааг харж болно. Гэсэн хэдий ч, Бетпақдалагийн популяцийн тоо толгой



**Зураг 1. Казахстаны бөхөнгийн популяци**



**Нисдэг тэрэгнээс бөхөн тоолж байгаа нь. © КБТЗХН**

өмнөх жилийн популяциас харьцангуй бага ажиглагдсан нь 2015 онд тус нутагт бөхөн бөөнөөр хиарсаны дараа хараахан нөхөн сэргэж амжаагүй байгааг илтгэнэ. Гэхдээ уг зүйлийн биологийн онцлогт тулгуурлан үзвэл удалгүй нөхөн сэргэнэ гэсэн итгэлийг бидэнд өгч байна.

Сүүлийн үед хийгдсэн томоохон судалгааны дүнгээр Уралын популяци сүүлийн хэдэн жилийн хугацаанд тогтвортой өсөж, 35 хувиар нэмэгдсэн байна. Бетпақдалагийн популяцид ч гэсэн мөн адил өсөлт ажиглагдаж байгаа нь өвлийн уур амьсгал, идэвхтэй хулгайн ан байхгүй харьцангуй тааламжтай нөхцөлд амьдарч буй бөхөнгийн популяцид ердийн зүйл гэж үзэж болно.

Устюртын популяцийн хувьд илүү эмзэг хэвээр байна. Популяцийн тоо толгой буурч буй гол шалтгаан нь хулгайн ан юм. Гэсэн хэдий ч, сүүлд хийгдсэн судалгаагаар популяцид эрэгчин амьтны тоо бага байгаа ч өсөлтийн эрчмийг үзвэл эрэгчин амьтан хангалттай байгааг харуулна. Популяцийн хэмжээ буураагүй хэдий ч маш цөөн тоо толгой байна.

2016 оны агаарын судалгааны нэг ялгагдах онцлог нь АН 2 онгоц хэрэглэж



### Өгүүлэл (үргэлжлэл)

байсны оронд Eurocopter 145 гэсэн шинэ загварын нисэх онгоц ашигласан явдал юм. Ингэснээр судалгааг стандартад нийцсэн байлгахын зарим нэг өөрчлөлтийг хийх зайлшгүй шаардлагатай болсон. Энэ бол нисдэг тэрэгний тавцан дээр сууж буй тоологч нисэх онгоцны цонхоор харснаас илүү их өргөн талбайг харах боломжтой бөгөөд шинэ харилцаа холбооны систем нь оновчтой биш, цөөн тоологч оролцох боломжтой зэрэг байсан. Үүнээс гадна, судалгааны трансектийн тэмдэгжүүлэлтийг тогтоох болон нислэгийн үргэлжлэх хугацаа хязгаарлагдмал байсантай холбоотой зарим нэг техникийн асуудал гарсан байна. Гэхдээ шинэ түлшний савны системийг ашиглан шатахуунаа хээрээс цэнэглэх зэргээр эдгээр асуудлыг



Ажиглагчийн баг. © КБТЗХН

шийдвэрлэсэн. Бүх асуудлыг удалгүй шийдвэрлэж, шинэчлэн боловсруулсан хээрийн судалгааны протоколтой бүрэн нийцүүлэн судалгааг явуулсан нь өмнөх судалгааны үр дүнг 2016 оны үр дүнтэй харьцуулах боломжтой болгож байна.

### Степной ДЦГ-ын хавар

*Владимир Калмыков<sup>1</sup>, Мария Воронцова<sup>2</sup>*

*1 Степной ДЦГ, [limstepnoi@mail.ru](mailto:limstepnoi@mail.ru); 2 Амьтны эрүүл мэндийг хамгаалах олон улсын төвийн Орос дахь салбар нэгж, [mvorontsova@ifaw.org](mailto:mvorontsova@ifaw.org)*

Хавар цаг. Тал хээр ногоон өнгөөр хурдан солигдож, зарим газар нь цэцэрлэгт хүрээлэн болж хувирна. Шувууд эх нутагтаа эргэн ирж, тал хээр тэдний шулганаанаар дүүрдэг. Гэхдээ хүүхдүүд бөхөн Степной дархан газарт ирэх тэр цаг ойртож байна гэж хүлээдэг нь хамгийн чухал. Энэ нь Дархан газарт ирж төллөлж байгаа 16 дахь тохиолдол бөгөөд ажилтнууд түүнд зориулан тусгайлан бэлтгэл базаасан байна.

Жил бүрийн тавдугаар сард албан ёсоор баталгаажсан 54,000 га Бөхөнгийн нөхөн үржлийн бүсэд бөхөн орж ирдэг. Астрахань мужийн Байгалийн менежмент, хүрээлэн буй орчны хамгааллын албаны зааварчилгаагаар Нөхөн үржлийн бүсээр дайран өнгөрөх бүх зам дээр машины хөдөлгөөнийг хязгаарлаж, жолооч нарт зориулан түр зуур зам хаасныг мэдээлсэн

таних тэмдэг байрлуулж, бөхөн төллөх тухайн цаг үед амар тайван байдлыг хангадаг. Энэ дэлхий дээр ирж буй шинэ амьдралд гайхамшигтай мэдрэмж үүсэх бөгөөд энэ нь бүх зүйл үржлийн үед бэлэн болсоныг илтгэнэ. Гэвч бөхөнгийн янзаганууд гарч эхлэх үеэр төллөх бөхөнгүүд Астраханы тал нутгийн тал тэр жижиг хэсгийг олж очиж чадаагүй. Энэ үед цаг агаарын нөхцөл байдал хүндэрсэн байсан. Тэр ч байтугай өндөр настай оршин суугчид хүртэл цаг агаар иймэрхүү нөхцөл байдалтай байсныг огт санахгүй байгаа бөгөөд хар салхитай адил хүчтэй салхи, хүчтэй аадар бороо нь хээрийн зам харгуйг Венецийн сувгийг санагдуулам болгож, асар их усанд автсан хээр талд энэ бүхнээс айсан бөхөн болон хүмүүсийн аль аль нь адилхан зогсохыг тэсч ядан хүлээж байв.

Энэ бүх зүйлийг үл хайхран бөхөнгүүд 20 орчим км-ийн зайтай орших хоёр газрыг сонгон байршиж байв. Төллөхөөр бөөгнөрсөн 2500 орчим шаргачин цаг агаар сайжрах үеийг хүлээж байлаа. Тавдугаар сарын 18-нд зуны улирал шиг нар халуунаар шарж, салхи зөөлөн сэвэлзэж, хөрс болон өвс ногоо хатаж эхэлсэн. Үдээс хойш хээр тал шинээр төрсөн янзагануудын эхийгээ дуудах өвөрмөц дуу, чимээгээр дүүрсэн.

Энэ жил Дархан газрын багийнхан төллөх газрыг шинжлэх ухааны зориулалтаар, ямар нэгэн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх байдлаар шийджээ. Төллөлт ердөө долоо хоног үргэлжилж, эх янзагануудын үхэл хорогдол маш бага түвшинд байсан. Бид бөхөн төллөж буй газар луу тас алс холоос тогтмол нисэн ирж байгааг ажигласан. Энэ удаад тэд голдуу эхэс идэн, өөрсдийн идэш тэжээлийн хэрэгцээгээ хангаж байсан. Тиймээс 2016 онд популяцийн өсөлт сайн байгаа гэдэгт бид итгэлтэй байна.

Дархан газрын нэг хэвийн амьдрал өөрчлөгдөж үнэгний гавар, чонын бэлтрэг, туулайн бүжин эргэн тойрон дэвхцэн харайж, махчин шувуудын ангаахай үүрэндээ өсөн томорч, залуу тогоруунууд өөрсдийн эцэг, эхээ даган аажуухан дайван явж харагдана. Алмаазан ногоон өнгөөр гялтганах хээр тал дунд энэ бүхэн харагдана. Удалгүй энэ гайхалтай дүр зураг



Степной ДЦГ-ын байгаль хамгаалагчийн баг. © Николай Юденко



Хосе Антонио Хернандез Бланко (Экологич-эволюцийн хүрээлэн)-ийн хөөргөсөн дроноос Степной ДЦГ-ын байгаль хамгаалагчийн байрны харагдах байдал

илүү хатуу ширүүн дүр зургаар солигдож, байгалийн болон (жишээ нь, хуурай аянган шуурганы улмаас) хүний гаралтай гал түймрийн аюултай хаврын улирлын олон өнгөт хивс шар өнгөтэй болон хувиран өөрчлөгддөг. Галаас үүдсэн гарз хохирлыг багасгахын тулд ажилтнууд дархан газрын замыг цэвэрлэж, ялангуяа галын аюултай бүсэд газрыг хагалан, сийрэгжүүлж байна. Энэ ажлыг Ургамал, амьтан хамгаалах олон улсын нийгэмлэгийн (IFAW) ОХУ-ын салбарын дэмжлэгтэйгээр хамт Астрахан мужийн Байгалийн менежмент, хүрээлэн буй орчныг хамгаалах алба санхүүжүүлсэн. Болзошгүй гал түймрийн урьдчилан сэргийлэх, унтраахад орон нутгийн тариаланчдаас үзүүлэх тусламжийг хэтрүүлэн үнэлэх нь хүндрэлтэй боловч дархан газрын ажилтнууд саяхан тэдэнтэй байгаль, эх газар нутгаа хамгаалах, хайрлахад харилцан ойлголцох, олон талын туслалцаа үзүүлж байх найрсаг гэрээг байгуулсан. Бид хамтдаа дархан газарт байх ан амьтдыг хамгаалах боломжтой гэдэгт итгэлтэй байна.

Эцэст нь хэлэхэд, дархан газарт анхаарал тавин ажиллаж байгаа Астрахан мужийн Байгалийн менежмент, хүрээлэн буй орчныг хамгаалах алба төдийгүй энэ жил маш их зүйлийг хийхэд тусалсан хамтран ажиллагсаддаа гүн талархал

## Өгүүлэл (үргэлжлэл)

илэрхийлье. Дархан газарт байгаль хамгаалагч нар амарч болох жижиг байр барьж байгуулахад бидэнд тусалсан Бөхөн хамгаалах холбоонд талархаж байна. Байгаль хамгаалагчдын байрыг нарны батерейгаар тоноглон биднийг гэрэл, гэгээтэй байх боломжийг олгосон Амьтдын эрүүл мэндийг хамгаалах олон улсын сангийнхандаа баярлалаа. Биднийг шатахуунгүй байхад санхүүжилт босгож өгсөн ДБХС-ийн ОХУ-ын хөтөлбөрийн газарт талархаж байна. Өөр юу билээ.. Энэ жил бидний урт удаан хугацааны мөрөөдөл биелж байна. Амьтдын эрүүл мэндийг хамгаалах олон улсын сангаас бэлэглэсэн 2 автомат камер бидний нүднээс далд болж байгаа (ялангуяа харанхуй үед) үйл явдлыг баримтжуулахад туслах болно <https://www.instagram.com/p/BHR67clASBC>.

2016 оны хавар болон зуны эхэн сард Санкт-Петербургийн их сургууль, ОХУ-ын ШУА-ийн Экологи, эволюцийн хүрээлэнгээс эрдэмтэн судлаачид, Англиас гэрэл зурагчин (<https://nat.astrobl.ru/press-release/saygaki-v-astrahanskoy-oblasti-pod-nadyozhnoy-zashchitoy>) болон <http://www.ifaw.org/-aac> international/news/saiga-sanctuary-be-featured-our-planet-



Бөхөнгийн бүл © Андрей Гилев

series), түүнчлэн ДБХС-ийн ОХУ дахь салбарын Кавказ дахь салбарын гишүүд, Волгоградаас эко жуулчид (<http://africa-v-tebe.livejournal.com/54027.html>) ирсэн явдалд бид талархалтай байна. Биднийг зорин ирсэн хүмүүсийг бид зочлон хүлээж авах болно!

Эцэст нь бидний энэхүү жижигхэн ажилд оролцсон бүх гишүүдийн зүрх сэтгэлээс хэлдэг, олонд түгсэн «Үр дүн гарч байна» гэсэн үг байна! Бидний хүсэн хүлээж буй үр дүн нь баруун хойд Каспийн бүс нутгийн таагүй нөхцөлд бөхөн эсэн мэнд үлдэж, хойч үедээ энэ зүйлийг хамгаалан үлдээхэд шаардлагатай бүхнийг хийх явдал юм.

## «Сайгачий» БНГ-н талаарх оролцогч талуудын ойлголтыг үнэлэх нь

*Соня Данда<sup>1</sup>, Елена Быкова<sup>2</sup>, Е.Ж.Милнер-Гулланд<sup>3,2</sup>*

*1. Лондонгийн Эзэн хааны коллеж, [sonia.k.dhanda@gmail.com](mailto:sonia.k.dhanda@gmail.com); 2. Бөхөн хамгаалах холбоо; 3. Оксфордын их сургууль*

### Оршил

Узбекистаны Каракалпакистан дахь Сайгачий БНГ Устюртын бөхөнгийн популяци хамгаалах зорилгоор 1991 онд байгуулагдсан. БНГ нь ДБХХ-ний хамгаалалттай газрын IV ангиллаас иж бүрэн ландшафтын нөөц газар гэсэн ангилал руу шилжиж дахин байгуулагдаж (Дээрх мэдээг Шинэ мэдээнээс үзнэ үү) ДБХХ-ны хамгаалалттай газар нутгийн 16 ангилалд орсон. БНГ-ын чиглэл

шинэчлэгдэж, бүс нутагт газрын тос, хийн үйлдвэрлэлээс хүрээлэн байгаа орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг нөхөх замаар санхүүжих менежменттэй, санхүү болон нөөц нь тодорхой, үр дүнтэй хамгаалалттай газар нутаг болох зорилготой юм.

Лондонгийн эзэн хааны коллеж, Бөхөн хамгаалах холбооны хамтарсан төслийн хүрээнд дахин чиг үүргийг тодорхойлох ажлын урьдатгал болгон Сайгачий нөөц газарт хандах хандлага, оролцогч талуудын



ойлголтыг тодорхойлох ажил хийгдсэн. Энэхүү зөвлөмж нь Нөөц газарт эерэгээр болон сөргөөр нөлөөлж болохуйц бүх талуудад боломж өгч, менежментийн төлөвлөлтөнд хувь нэмрийг нь оруулахад чиглэгдсэн. Мөн бид Узбекистаны хамгаалалттай газар нутгийг оролцооны аргаар үнэлэхэд энэ хандлагын ач холбогдлыг ашигласан.

Мэдээлэл цуглуулах ажил Ташкент болон Нукус хот болон хөдөө орон нутгийн хоёр суурин болох Кырк-Кыз, Кубла Устюртад 2015 оны 5 сарын 24-6 сарын 15 хүртэл хийгдсэн. Бид Сайгачий нөөц газрын дахин зохион байгуулалтанд нөлөөлж болзошгүй ямар зүйл байгааг тодруулахын тулд бүлгийн ярилцлага, хагас зохион байгуулалттай ярилцлага, асуулга ашигласан. Мөн нөөц газарт нөлөө үзүүлж болох бүлэг тус бүрийн эерэг болон сөрөг нөлөө юунд байгааг, нөөц газрын тэдэнд болон бусдад ямар ашигтай, ямар зүйл гаргаж болох талаар асуулга явуулсан. Бид оролцогчдыг гурван бүлэг болгон ангилсан:

1. Кырк-Кыз, Кубла Устюрт тосгодоос ирсэн бүлэг болон хувь хүмүүсийг төлөөлөх орон нутгийн иргэд.

2. НҮБХХ, Үндэсний аюулгүй байдлын алба, Госбиоконтрол, Ан агнуур ба загас

судлалын хэлтэс зэрэг үндэсний болон олон улсын байгууллага

3. ЭША, багш, археологич зэрэг нөөц газарт шууд бус сонирхлоор хандах сонирхогч талууд.

Бид хамтын оролцооны жишээн дээр 11 удаа бүлгийн ярилцлага хийж, 13 хагас зохион байгуулалттай асуулга явуулсан. Бөхөнгийн экологи, хамгааллын талаарх оршин суугчдын мэдлэгийг цуглуулах зорилгоор 34 асуулга авсан.

### Судалгааны үр дүн

Ерөнхийдөө орон нутгийн иргэд Устюртын бүс нутгийн биологийн олон янз байдал, чиг хандлага, бөхөн агнуурын тухай хуулийн талаар мэдлэгтэй байсан. Орон нутгийн оршин суугчид, албан байгууллага, сонирхогч талуудын зонхилох сэдэв нь орон нутгийн хүмүүс нөөц газраас хол оршин суух учир нөөц газарт сөрөг нөлөө үзүүлэхгүй, зөвхөн малчид, хулгайн анчид тус газарт хааяа нэг очих магадлалтай гэж байв. Тухайн бүс нутаг дахь бөхөнгийн тоо толгой эрс буурснаас одоо түүнийг олж харахад хэцүү байдаг учир бөхөнгийн хулгайн ан нь тийм ч их холбогдолтой зүйл биш гэж үзсэн. Бүлэг тус бүрийн хүмүүсийн дурдаж байсан хулгайн ан нь Сайгачий нөөц газрын хамгийн том аюулын нэг гэж үзэж байна.



Байгаль хамгаалагчийн байртай ойрхон байх гүний ундаргатай нуур орчимд зоосон автомат камерт авагдсан бөхөнгийн зураг

## Өгүүлэл (үргэлжлэл)

### Сайгачий нөөц газрын талаарх оролцогч талуудын ойлголт

Одоогийн хамгаалалттай газар нутаг болон дахин зохион байгуулах үйл явцын талаарх ойлголт оролцогч талуудын бие биетэйгээ холбоотой харилцан адилгүй хүчин зүйлүүд хэрхэн нөлөөлж байгааг харуулав (Зураг 1).

Орон нутгийн оршин суугчид одоогийн нөөц газар, түүний чиг үүргийн талаар ядмаг ойлголттой, байгаль хамгаалагч нарт үл итгэх хандлагатай бөгөөд Засгийн газар нь бодит байдалд бөхөн сэргээх болно гэдэгт итгэл багатай байгааг харуулж байна. Албан ёсны байгууллага болсон Сайгачий нөөц газар нь нөөц газарт заагдсан санхүү, чадавхи, менежменттэй болох хүртлээ өөрийн зорилгоо биелүүлж чадахгүй бөгөөд сайтар зохион байгуулагдан ажиллаж ажлаа хийх боломж бүрдэнэ. Албаны байгууллагууд Засгийн газар төсөл дээр гарын үсэг зуран эцэслэх хүртэл Сайгачий нөөц газрын өнөөгийн ажлын төлөвлөгөөг хэлэлцэхгүй гэдгийг онцолсон бөгөөд өнөөг хүртэл НҮБХХ толгойлох үүрэгтэй оролцож байна. Сонирхогч талууд (эрдэмтэн,


багш нар) дахин зохион байгуулах үйл явцыг дэмжихээ илэрхийлж, нөөц газрын ирээдүйд эерэг хандлагатай байна.

### Үр ашиг, зардал, нөөц газрын нөлөө

Албаны байгууллагууд, сонирхогч талууд, орон нутгийн оршин суугчдаас нөөц газрын бодит үр ашиг, оролцогч талуудын зардлын талаар асууж, хувь хүн эсвэл бүлэг нь хэрхэн нөөц газарт эерэг, сөрөг нөлөө үзүүлж болох талаар тайлбар хүссэн юм. Хэлэлцүүлэг бүрийн ижил төстэй санааг нэгтгэн 1-р хүснэгтэд үзүүлэв.

### Хамтын оролцоотой төлөвлөх аргыг үнэлэх

Ерөнхийдөө энэ арга нь оролцогч талуудын оролцоонд тулгуурлан хийгдэх судалгааны үзэл баримтлал нийтлэг бус, оршин суугчдад хүрэх нь хязгаарлагдмал учраас бүс нутагт болон хэсэгчилсэн байдлаар хэрэгжүүлэх нь хүндрэлтэй юм. Эдгээр саад бэрхшээлийг үл харгалзан, оролцогч талуудаас зарим мэдээлэлийг цуглуулж чадсан бөгөөд оролцогч талууд хувь нэмэр оруулж чадна гэж харуулж байна.



Зураг 1. “Сайгачий” нөөц газрыг дахин зохион байгуулахад чиглэсэн бие биетэйгээ холбоотой харилцан адилгүй хүчин зүйлүүд. Энэ онолын схемийг Настраны судалгаагаар хийв.



Үр ашиг	Эерэг нөлөө
<b>Орон нутгийн оршин суугчид</b> <ul style="list-style-type: none"> <li>Ажлын байр нэмэгдэх (байгаль хамгаалагч гэх мэт)</li> <li>Хэрвээ бөхөн нөхөн сэргэвэл тэд агнуурын амьтан болно</li> </ul>	<b>Орон нутгийн оршин суугчид</b> <ul style="list-style-type: none"> <li>Нөөц газарт ажиллана (бүтээн байгуулалт, эко аялал жуулчлал, байгаль хамгаалагч гэх мэт)</li> </ul>
<b>Үндэсний болон Олон улс</b> <ul style="list-style-type: none"> <li>Байгалийн өвийг хамгаалах</li> </ul>	<b>Бүс нутгийн засаг захиргаа</b> <ul style="list-style-type: none"> <li>Нөөц газрын ажиллах боломжийг хангах (тээвэр, шатахуун гэх мэт)</li> </ul>
<b>Бүс нутгийн засаг захиргаа</b> <ul style="list-style-type: none"> <li>Хэрвээ бөхөн нөхөн сэргэвэл тэд агнуулах боломжтой болж орлого олно</li> </ul>	<b>Газрын тос, хийн компаниуд</b> <ul style="list-style-type: none"> <li>Нөөц газарт санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлэх</li> </ul>
<b>Судлаачид</b> <ul style="list-style-type: none"> <li>Тухайн нутагт судалгаа, шинжилгээ хийх боломж</li> </ul>	
Зардал	Сөрөг нөлөө
<b>Газрын тос, хийн компаниуд</b> <ul style="list-style-type: none"> <li>Нөөц газарт хайгуул хийх боломж хязгаарлагдмал</li> </ul>	<b>Орон нутгийн оршин суугчид</b> <ul style="list-style-type: none"> <li>Бөхөнг мах, эврийн зорилгоор агнах</li> </ul>
<b>Орон нутгийн оршин суугчид</b> <ul style="list-style-type: none"> <li>Байгалийн нөөцийн ашиглалт хязгаарлагдмал ( малын бэлчээр гэх мэт)</li> </ul>	<b>Газрын тос, хийн компаниуд</b> <ul style="list-style-type: none"> <li>Дэд бүтцийг барьж байгуулвал биологийн төрөл зүйлд сөрөг нөлөө үзүүлнэ</li> </ul>

**Table 1. Оролцогч талуудаас нөөц газрын үр ашиг ба зардал, нөөц газарт үзүүлэх бодит нөлөөллийн талаар оролцогч талуудын дунд хийсэн хэлэлцүүлгийн үндсэн санаа**

Оролцооны үйл явц нь шинээр гарч ирж буй зүйл бөгөөд Узбекистанд анхлан туршиж байгаа ба эдгээр аргачлал нь хууль эрх зүйн орчинд дэмжлэг үзүүлэх эсвэл нэмэлт оруулж чадна. Тиймээс энэ арга нь төлөвлөлтийн үйл явцыг дэмжих арга хэрэгсэл болох боломжтой.

### Зөвлөмж

Энэхүү зөвлөмжийг Устюртад Бөхөн хамгаалах холбооны ажлаар дамжуулан хэрэгжүүлэх болно. Судалгааны үр дүнд дараах зөвлөмжийг санал болгож байна:

“Сайгачий” нөөц газрыг дахин зохион байгуулсаны дараа эхний ээлжинд:

- Устюртын бөхөнгийн тархац нутагт хулгайн ангийн эсрэг эргүүлийн чадавхийг бэхжүүлэх.
- Нөөц газрын нийгэм, биологийн аль алиных нь нөлөөллийг хянах шалгуур үзүүлэлтийг боловсруулах зорилгоор “Сайгачий” нөөц газрын менежментийн төлөвлөгөөний хэлэлцүүлэгт туслалцаа үзүүлэх.
- Орон нутгийн иргэд, сонирхогч талуудыг дахин зохион байгуулалтын үйл явцын шинэчилсэн мэдээллээр хангах.
- Хэвлэл мэдээлэл болон орон нутгийн төрийн байгууллагын идэвхтэй оролцоотойгоор нөөц газар байгуулагдсаны

### Өгүүлэл (үргэлжлэл)

баярыг орон нутгийн болон үндэсний хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх

“Сайгачий” нөөц газрыг дахин зохион байгуулсаны дараа хоёрдахь ээлжинд:

- Хээрийн аялал, экологийн хичээл хийх талаарх сургуулиудад зориулсан боловсролын хөтөлбөр боловсруулах.
- Орон нутгийн иргэдэд эн тэргүүнд шаардлагатай байгаа зүйлсийн тухай, бүс нутгийн экологийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, байгаль хамгаалагчдын ёс суртахууны талаар сургалт хийж, чадавхийг бэхжүүлэх.
- Казахстанд бөхөн хамгаалах багтай хамтрах, харилцааг бэхжүүлэх, Узбек, Казакын нутагт хил дамнасан тусгай хамгаалалттай газар байгуулах чиглэлд анхаарах

#### Талархал

Уг судалгааг Бөхөн хамгаалах холбоогоор дамжуулан байгаль хамгаалах Витлей

## Зарлал

**Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенци болон Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Залуу хамгааллын лидер хөтөлбөрөөс ивээн тэтгэж буй Бөхөн хамгаалах холбооны жижиг тэтгэлэгт хөтөлбөрийн 2016 оны ялагчийг зарлаж байна.**

**Карлин Самуэл, Бөхөн хамгаалах нийгэмлэг, [mail@saiga-conservation.com](mailto:mail@saiga-conservation.com)**

Эхний ялагч нь **ОХУ**, Степной дархан газрын байгаль хамгаалагч нарын баг юм. Баруун хойд пре-Каспийн бөхөнгийн популяцийн төлөв байдал маш аюултай хэвээр байгаа бөгөөд одоогоор 3500 орчим амьтад байна. Гол аюул нь хулгайн ан. 2000 орчим бөхөн Степной ДЦГ-ын дотор амьдарч байна. Одоогоор 10 байгаль хамгаалагчтай баг үргэлж үүргээ гүйцэтгэн, хулгайн анчдад нэг ч бөхөнд хор хөнөөл учруулахгүй нөхцлийг бүрдүүлэхээс гадна тэдгээрийн амьдрах орчныг хэвийн тогтвортой байлгахад анхааран ажиллаж



Устюрт дахь судалгааны баг.  
© Александр Есипов

сангаас санхүүжүүлсэн билээ. Бид тэдний дэмжлэг, Узбекистан дахь судалгааны баг, Ташкент хотноо байх Узбекистаны Шинжлэх Ухааны Академид талархаж байна. Бүлгийн ярилцлага, санал асуулгад оролцсон хүн бүрт баярлалаа.

Энэ жил бөхөнгийн тархац нутаг дахь орон нутгийн байгаль хамгаалагчдын санал болгосон гурван сонирхолтой төслийг дэмжих болсондоо бид баяртай байна.

шинжлэх ухааны төв болж нэр хүнд нь өсөн нэмэгдэхэд байгаль хамгаалагч нар идэвхтэй ажиллаж байгаа явдалд талархаж байна. Тэдний ажлын энэ чухал бүрдэл хэсгийг бэхжүүлэх зорилгоор бид шинэ байшинг барих ажлыг санхүүжүүлэх болно. Энэ нь дархан газрын дотор байрлах бөгөөд эрдэмтэд, кино бүтээгчид болон байгаль хамгаалагч нарын зочлох гол төв болох юм. Байгаль хамгаалагч нар нь өөрсдийн зэрлэг ан амьтдыг хамгаалахад дархан газрын гүйцэтгэж байгаа ач холбогдлын талаар орон нутгийн хүмүүст мэдээлэх, тэдэнд хамгааллын үйл ажиллагаанд оролцох урам зоригийг өгөх зорилгоор байгаль орчны боловсрол олгох үйл ажиллагаа зохион байгуулах боломжтой болно.

Дараагийн ялагч нь Казахстаны БНУ-ын Байгаль орчны нийгэмлэгийн дарга Бибигул Сарсенова юм. Энэхүү шагналыг 70,000 амьтантай Казахстаны Уралын бөхөнгийн популяцийг хамгаалахад олон нийтийн хандлагыг хянаж, түүнийг идэвхжүүлэх зорилгоор түүнд олгож байна. Тэрээр бөхөн рүү чиглэсэн орон нутгийн хүмүүсийн хандлага, бүс нутагт явагдаж байгаа хулгайн ангийн шалтгааныг тодорхойлохын тулд КБТЗХН-ийн мэргэжил нэгт нөхдүүд, хүүхдийн Тал хээрийн зэрлэг ан амьтны клубийн орон нутгийн сүлжээтэй хамтран ажиллах болно. Бибигул мөн эдгээр ховордож буй амьтдад тулгарч буй асуудал руу хандсан байгаль орчны боловсролын үйл ажиллагааг явуулан, орон нутгийн сургуулийн сурагчид, уран бүтээлчид, байгаль орчны байгууллага, олон нийтийн хүрээлэнтэй хамтран ажиллах төдийгүй тал хээрийн амьтдыг хамгаалах клубийг шинээр үүсгэн бий болгох зорилгоор өөр өөр сургуульд ажиллах болно. Түүний төслийн дагуу бөхөн гаршуулан үржүүлэх хөтөлбөр бүхий Баруун Казахстаны Таскалинском дүүргийн биологийн төрөл зүйлийг хамгаалах төвд хөтөчтэй аялал зохион байгуулах болно.



“Степной” нөөц газрын байцаагч нарын баг

Эцэст нь хэлэхэд, ОХУ-ын Халимагийн Бүгд Найрамдах улсаас Екатерина Очирова болон Надежда Пюрвенова нарт «Бөхөн бидний өвөг дээдсийн амьд өв» нэртэй товхимол боловсруулах ажилд зориулан жижиг тэтгэлэг олгосон байна. Бөхөнгийн тухай шүлэг, дуу, уран зураг ба ардын аман яриаг эмхэтгэн гаргасан энэ товхимол бүс нутагт сургууль, номын санд тараагдах болно. Энэ нь орон нутгийн ард түмний соёлын өвд бөхөн хэрхэн нягт холбогдсоныг, түүхэн үйл явдлаар дамжуулан соёлын уялдаа холбоо, билэгдэл, эртний холбоосуудыг онцлон харуулж уг зүйлийг хамгаалахад хүмүүсийг урамшуулах, мэдээлэл өгөх зорилготой юм. Бөхөн хамгаалалд тулгарч байгаа өнөөгийн хандлага, алдартай байгаль хамгаалагч Улдис Кнакисын бөхөнг хамгаалж байгаад амь үрэгдсэн эмгэнэлт түүхийн тухай өгүүлэх болно. Энэхүү хүчирхэг, ач холбогдолтой товхимол нь бөхөнгийн ач холбогдлыг хүмүүст ойлгуулахад, хүн бүр түүний хамгаалалд оролцож болохыг мэдрэхэд туслах болно.

Манай шагналыг хүртсэн хүн бүрт баяр хүргэхийн ялдамд ойрын хугацаанд таны төслийг хүлээн авахдаа таатай байх болно.

Бөхөн хамгаалах нийгэмлэг нь байгаль хамгаалагч нарын дараагийн үеийг дэмжих нь чухал байгааг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд Залуу хамгааллын удирдагчид



## Зарлал (үргэлжлэл)



Бибигуль Сарсенова

(хувь хүн эсвэл баг хамт олон) шагналыг Бөхөн хамгаалах нийгэмлэгтэй хамтран ажилладаг улсаас нэг дэвшигч хүлээн авдаг бөгөөд тэдний байгаль хамгаалах төслүүдийг хэрэгжүүлэх боломж олгох



Екатерина Очирова

тэтгэлэг юм. Зэрлэг амьтан хамгаалах сүлжээнээс ивээн тэтгэсэн 2016 оны тэтгэлгийг гардан авсан ялагчийг зарлаж байгаадаа таатай байна.



Надежда Пюрвенова

## Бөхөн хамгаалах нийгэмлэгийн 2016 оны Залуу хамгааллын удирдагчид шагналыг хүртэгсэд

*Карлин Самуэл, Бөхөн хамгаалах нийгэмлэг, [mail@saiga-conservation.com](mailto:mail@saiga-conservation.com)*

Казахстанд Батима Бермухамбетовна Уталинан удирддаг тал хээрийн амьтдыг хамгаалах "Акбокен" клубын 12-14 насны дөрвөн хүүхэд орон нутагтаа, өөрсдийн сургуулийн хүүхдүүдэд урам зориг өгөх хөтөлбөр хэрэгжүүлэн явуулах болно. Энэ баг нь байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд таваас арван нэгдүгээр ангийн хүүхдүүдийг оролцуулах, хүрээлэн буй орчны гинжин хэлхээг эхлүүлэх зорилготой "Бөхөнгийн найзууд"-ын тойрогийг байгуулах болно. Акбокен нь Бөхөнгийн найзуудад бөхөн хамгааллын талаар яриа хийн, үзэсгэлэн, зурагт хуудас, сонин, хүүхэлдэйн кино гэх мэт зүйлсээр дамжуулан тэднийг дагаж буй хүүхдүүдэд мэдээлэл хийх болно. Түүнчлэн мэдээлэл түгээх бүлэг хэлбэрээр зохион байгуулж, хүрээлэн буй орчныг хамгаалах үйл ажиллагаа, хээрийн аялал зохион байгуулах болно. Мөн тэдний ажилд оролцох орон нутгийн их сургуулийн биологийн тэнхимийн гишүүдийг дэмжин



Бөхөн хамгаалах нийгэмлэгийн Залуу хамгааллын удирдагч 2016 шагналыг хүртсэн Казахстаны Тал хээрийн зэрлэг амьтдыг хамгаалах "Акбокен" клубийн гишүүд

ажиллах болно. Эцэст нь, ямар ч логогүй бүлэг байхгүй тул тэд Бөхөнгийн найзууд хэмээх шинэ бүлгийн лого боловсруулах уралдааныг сургуулийн хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөж байна.

ОХУ-ын Халимагийн БНУ-ын Зэрлэг амьтан судлах төвд англи хэлний багшаар

ажиллаж байгаа 27 настай Айгул Маратовна Айтбаева манай нэг ялагч юм. Тэрээр Бөхөнгийн өдрийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд зохион байгуулалтанд тусалсан бөгөөд орон нутгийн сургууль, олон нийтийн дунд бөхөнгийн талаарх мэдээлэл сурталчилгааны кампанит ажил явуулсан байна. Тэрээр орон нутгийн сургууль дээр Бөхөн хамгаалах нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр "Амьд өв" тал хээрийн амьтныг хамгаалах клубд туслах ажлаа үргэлжлүүлэн хийсээр байна. 2014 онд тэрээр таваас долоо хүртэлх ангийн хүүхдэд зориулсан "Гайхалтай нүүдэлчин" өнгөт товхимол бичиж, хэвлүүлсэн учир манай Залуу хамгааллын удирдагч шагналыг хүртсэн юм. Энэ жил бөхөнгийн тархац нутагт байх гурван тосгонд "Бөхөнг авраач" тэмцээнийг зохион байгуулах төлөвлөгөөтэй байна. Айгул хууль бус агнуурын талаарх мэдээлэл сурталчилгаа, хөдөө орон нутгийн тосгодод байх бөхөнгийн гаралтай бүтээгдэхүүний борлуулалтын асуудлыг тусгасан хамгийн сайн зурагт хуудсыг хүүхдүүдээр хийлгэхээр ажиллаж байна. Энэхүү уралдаанд ялсан хамгийн сайн зурагт ухуулах хуудсыг хэвлэн олшруулж, орон нутгийн таван тосгонд тараах болно. Бөхөн хамгааллын талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх зорилготой "Гайхалтай нүүдэлчин" номыг гардуулан өгч, яриа хийн, эдгээр таван тосгон бүрт айлчлан Тал хээрийн амьтдыг хамгаалах клубийнхэнтэй хамтран ажиллахаар Айгул төлөвлөж байна.

Монгол улсаас Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газарт ажиллаж байгаа залуу судлаач Даланнастын Мөнхнастад ихээхэн ач холбогдолтой шинжлэх ухааны ажил хийх зорилгоор тэтгэлэг олгосон байна. Монгол бөхөн халуун, хуурай нөхцөлд сайн дасан зохицсон хэдий ч усгүйгээр маш богино хугацаанд явж чадна. Гэсэн хэдий ч, ундны усны аюулгүй эх үүсвэр

хуурай улиралд маш хязгаарлагдмал байх бөгөөд бид одоогоор эдгээр амьтдын усны хэрэгцээ, шаардлагыг хараахан бүрэн гүйцэд ойлгоогүй байна. Олон байгаль хамгаалагчид усны нөөцийн үр дүнтэй менежмент нь тухайн газар дахь бөхөн болоод бусад амьтдыг амжилттай хамгаалахад чухал хүчин зүйл байж болох юм гэж үзэж байна. Энэхүү санаанд тулгуурлан Мөнхнаст бөхөнгийн усны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох шинжлэх ухааны судалгааг гүйцэтгэн, бүс нутгийн хэмжээнд бөхөн ундаалах уст цэгийн зураглалыг хийх болно. Энэ шинэлэг судалгаа нь одоо байгаа уст цэгүүдийг хэвээр хадгалах, түүнчлэн бөхөнгийн популяци, түүний хүрээлэн буй орчныг эрүүл, сайн сайхан хэвээр байлгахад уг чухал асуудлыг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах зорилготой менежментийн төлөвлөгөө гаргахад ТББ-ууд, эрх баригчид хамтран ажиллах боломжийг нөхцөлдүүлнэ.

Бөхөн хамгаалах нийгэмлэгийн Залуу хамгааллын удирдагч 2016 шагналыг хүртсэн Казахстаны Тал хээрийн зэрлэг амьтдыг хамгаалах "Акбокен" клубийн гишүүд; Халимаг болон Монгол улсын залуу хамгааллын удирдагч Айгул Айтбаева (зүүн) ба Даланнастын Мөнхнаст (баруун гар талд).



Халимаг болон Монгол улсын залуу хамгааллын удирдагч Айгул Айтбаева (зүүн) ба Даланнастын Мөнхнаст (баруун гар талд)

## Бөхөнгийн баатар

**Владимир Калмыков: Миний ажлын хамгийн сайхан нь Степной дархан газрын амар амгалан байдал юм.**

*Өнөөдөр бид Степной дархан газрын захирал Владимир Калмыковыг урин оролцуулж бөхөнд зориулсан түүний амьдралын тухай цөөн хэдэн асуулт тавилаа. Тэр бол хамгийн шилдэг бөхөн хамгаалах багын дарга бөгөөд дархан газрын анхны улсын байцаагч, дархан газрыг үүсгэн байгуулахад оролцжээ. Энэхүү ажилд оролцон, өөрийгөө бүрэн зориулж, бүхий л амь амьдралаа шингээж байгаа түүний оруулсан хувь нэмрийг нь үнэлэн Владимир Калмыков Астрахан, бүс нутгийн засгийн газраас нэг бус удаа шагнал авч байв. Түүний баг Бөхөн хамгаалах холбооноос Хулгайн ангийн эсрэг ур чадварын шагналыг хүртсэн юм.*

**Редактор: Та анх хэзээнээс бөхөнг сонирхож эхлэсэн бэ?**

**ВК:** Ойролцоогоор 50 гаруй жилийн өмнө намайг хүүхэд байхад Астрахан бүс нутагт бөхөн хаа сайгүй элбэг, ялангуяа энэ хорвоо дээрх аз жаргалтай мөчүүдийг үдсэн Промысловка тосгоны дэргэд ч байдаг байв. Тухайн цаг үед тосгоны хөвгүүд бид төрөлх тал нутаг дээгүүрээ нисэж байгаа мэт санагддаг эдгээр маш ер бусын, түргэн хөлтэй амьтанг шохоорхон хардаг байв.

**Редактор: Та хэзээнээс бөхөн хамгаалалд оролцон, түүний судалгааг хийж эхэлсэн бэ?**

**ВК:** Анх 1988 онд янз бүрийн шалтгааны улмаас өмнө нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байсан өөрийн амьдралыг эрс өөрчлөхөөр шийдэн Лиман дахь Ан агнуурын болон загас агнуурын нийгэмлэгт байгаль хамгаалагчаар орж, хулгайн анчдаас агнуурын аж ахуйн газар нутгийг хамгаалах, ан агнуурын хууль дүрмийг сахиулах үүргийг гүйцэтгэж эхэлсэн. Тэнд ахлах байгаль хамгаалагчаар ажиллаж байгаад дараа нь Астрахан бүс нутгийн Камышов агнуурын менежменттэй нутаг болон Лиман дахь Охотназор байгууллагад (агнуурын үйл ажиллагаанд хяналт тавих) ан агнуур хариуцсан мэргэжилтнээр ажиллан, бөхөн зэрэг агнуурын зүйлүүдийг хянах, мониторинг



**Степной дархан газрын захирал Владимир Калмыков**

хийх, мах идэшт амьтдаас хамгаалах, орон нутгийн хүмүүсийн ан агнуурын хууль, журмыг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих, байгаль хамгаалагчдыг дэмжин ажиллах, хууль бус ан агнуурыг хянах зэрэг үүргийг гүйцэтгэж байв. Энэ нь надад мэдлэг, туршлага хуримтлуулсан "анхан шатны сургууль" байсан бөгөөд тэнд зөвхөн өөрөө бөхөн хамгаалалд оролцоод зогсохгүй хамтран ажиллагсадтайгаа өөрийн туршлагаа хуваалцахад тусалсан цаг үе байв. 1994 онд өөрийгөө хангалттай суурь мэдлэг байхгүй гэдгийг ойлгосон учир Волгоград Хөдөө аж ахуйн академийн зайны сургалтын хөтөлбөрт хамрагдаж 2000 онд төгссөн. Бөхөн хамгаалалд болон надад тухайн жил ихээхэн ач холбогдолтой үйл явдал тохиосон нь Степной Улсын дархан газар Астрахан бүс нутагт албан ёсоор байгуулагдсан явдал юм. Үүсгэн





Гурван дайчин В.Калмыков, Н.Юденко, Г.Домовцов. © Г.Калмыкова

байгуулагдсан анхны өдрөөс эхлэн би улсын байцаагчаар ажиллаж эхэлсэн. Тэгээд л миний бөхөн хамгаалах, судлах үйл ажиллагаа эхэлсэн. Тэр цагаас хойш арван зургаан жил өнгөрч, одоо би бөхөнтэй хөршлөн амьдрах бүх амьтад, бөхөнг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй энэхүү өвөрмөц байгууллагын захирлаар ажиллаж байна.

**Редактор: Таны ажлын өдөр хэрхэн өнгөрдөг вэ?**

**БК:** Миний бүх ажил өдөр өдөр янз бүр байдаг ч сараар урьдчилан төлөвлөсөн байдаг. Хэрвээ албан ерөөндөө байхгүй эсвэл бичиг цаасны ажил хийгээгүй бол байгаль хамгаалагч, байцаагч нартайгаа дархан газраа тойрон явж, янз бүрийн үйл ажиллагаа явуулан, дархан газар дотор эсвэл хил дагуу амьдарч буй малчидтай уулзан ярилцдаг.

**Редактор: Бөхөнгийн тухай сонирхолтой түүх бидэнд ярьж өгнө үү?**

**БК:** Бөхөн үнэхээр гайхалтай амьтан. Та цаг хугацаа өнгөрөх бүрт түүний зан авирын шинэ, ер бусын ямар нэг юм зүйлийг эцэс төгсгөлгүй үүнийг харж болно. Хэн нэг нь үүнийг судлаад, судлаад л байгаа. Манай хамт олон эсвэл миний хариулж чадах ганц л асуулт байдаг нь бөхөн яагаад хамгаалалттай газар

нутгийг орхин үхэж ч мэдэх газар нутаг руу нүүдэллэдэг вэ гэсэн асуудал юм. Энэ амьтан хүмүүс бол маш хүнлэг гэдэгт найдах боломжтой юу? Бид үүнийг ойлгож чадахгүй л байна. Бөхөн төллөн, янзагаа гаргах нь бөхөнгийн амьдралын хамгийн баяр хөөртэй, хайрлууштай, бас маш их зовоодог цаг хугацаа юм. Эмэгчин бөхөн болон түүний янзаганы хоорондын харилцааны талаар маш олон сонирхолтой түүх ярьж болох ч та өөрийн нүдээр үзэх нь илүү дээр юм.

**Редактор: Таны ажилд тулгарч байгаа хүндрэлтэй зүйл юу вэ?**

**БК:** Энэ асуултанд хариулахдаа би өөрийнхөөрөө байж чадахгүй байх гэж бодож байна. Бөхөнгийн тархац нутагт бөхөн хамгаалах бусад байгууллагад угаасаа нэгэн адил байх хууль тогтоомжийн хрэгжилт сул, байгаль хамгаалагчдын цалин хөлс бага, бензин, шинэ тоног төхөөрөмжийн байнгын хэрэгцээ гол асуудал юм.

**Редактор: Энэ бүх хүндрэлийг хэрхэн шийдвэрлэж чадах вэ?**

**БК:** Энэ асуултын хариулт нь өмнөх асуултын хариултаас урган гарч ирэх бөгөөд цалин хөлсийг нэмэгдүүлэн, дархан газрын ар талын зохион байгуулалт, бүтцийг сайжруулан, засаг захиргааны бүтэц хоорондын ажлын уялдаа холбоог зохицуулан, хууль сахиулах байгууллагын оролцоонд тулгуурлан бөхөнг бүгдээрээ хамтран хамгаалах ёстой. Ингэхдээ улсын болон бүс нутгийн түвшинд улс төрийн бодлого шаардагдана. Үүнээс гадна, Степной дархан газрын улсын байцаагч нар бөхөнг хамгаалахад ялангуяа дархан газрын дотор төдийгүй түүний хилийг давсан хулгайн анчдыг саатуулах эрх мэдэлтэй байх ёстой. Бөхөн дархан газрыг орхин оддог нүүдлийн зүйл учир энэ нь маш чухал юм.

### Бөхөнгийн баатар (үргэлжлэл)

**Редактор: Таны ажлын хамгийн сайхан зүйл юу вэ?**

**БК:** Хөндлөн гулд хэрэн бэлчээрлэж буй бөхөнгийн сүрэг, нэг бутнаас нөгөө рүү туулай, үнэг гүйлдэн, өөрийн нүхнийхээ ойролцоо хөөгөө бэлдэж буй мэрэгчид, сүрэглэн нисэх шувуудыг хялбархан харж болох дархан газрын амар тайван байдал... Гэхдээ ийм амар амгалан байдал зөвхөн дархан газрын сайн зохион байгуулалттай багийн ажлын үр дүнд хүрч чадна. Манай хүмүүс бол миний ажлын онцлох хэсэг юм. Би нэг бус удаа хэлсэнчлэн 20 жилийн тэртээ ХАА-н яамны дэмжлэгтэйгээр өндөр түвшинд бэлтгэгдсэн мэргэжилтнүүдээс бүрдсэн Халимагийн бүгд найрамдах улсын бөхөн хамгаалах тусгай хэлтэс байгуулагдсан гэдгийг дурдах ёстой. Зах зээлд шилжсэнээр уг тасаг санхүүжилтгүй болж, томоохон эдийн засгийн хямралд өртсөн тул тэднээс илүү зүйл хүсэх хэн ч

байгаагүй. Мэдээжийн хэрэг, тэнд ямар ч бөхөн хамгаалах үйл ажиллагаа байхгүй болсоныг мэдэрсэн хулгайн анчид өөрсдийн "хар үйлс"-ээ хийж эхэлсэн юм. Тэдгээр хүмүүсийн тухай юу хэлэх вэ? Одоо бидний дунд байхгүй байгаа бизнес хөөсөн, энэ бүхний дараа ажилгүй хоцорсон бөхөн хамгаалах олон ажилтнуудын өмнөөс харамсах ёстой. Харин Степной дархан газарт удаан хугацааны турш хэрэгцээнээсээ илүүтэйгээр бөхөн хамгаалах үйлсэд өөрсдийгөө зориулсан хамгийн сайн мэргэжсэн хоёр хүн болох Геннадий Домовцов болон Николай Юденко нар бидний эгнээнд үлдсэн нь азтай хэрэг юм. Хоёр жилийн хугацаанд дархан газрын хамгаалалтын түвшинг тогтвортой дээшлүүлэхэд тусалж чадах залуу боловсон хүчинд өөрсдийн баялаг туршлагаа өвлүүлэн аль хэдийн анхны мэргэжлийн багийг бий болгосон



Владимир Калмыков "Степной" нөөц газрын багийн хамт олонтой. © Александр Есипов

**Редактор:** *Бөхөн хамгааллын хэтийн төлөв ямар байна вэ? Энэ зүйлийг эсэн мэнд үлдэхэд туслахын тулд хамгийн түрүүнд урьдчилан юу хийх шаардлагатай вэ?*

**БК:** Энэ нь байгаль хамгаалалд итгэдэг хүн бүр бөхөнг хэзээ ч арилжааны ашиг, улс төрийн хэлэлцээрийн объект болгон ашиглахгүйгээр засгийн газрын холбогдох талуудад үүнтэй холбоотой асуудал дэвшүүлэх зэрэг өөрсдөөс хамааралтай бүх зүйлээс татгалзах нь нэн чухал ач холбогдолтой юм. Өөрийн үндсэн амьдрах орчиндоо өсөн тэлж, хорогдон буурч, тоо толгой нь унаж, өсөн тэсвэр хатуужил шаардсан цаг хугацааны түүхээр дамжуулан энэхүү үнэхээрийн гайхамшигтай, өвөрмөц, мартагдашгүй зүйл амьтныг хамгаалахад бүх хүмүүсийн үйл ажиллагааг чиглүүлж, уялдуулан нэгтгэх нь хамгийн чухал юм. Зөвхөн ингэснээр бид

энэ зүйл амьтныг эсэн мэнд үлдэхэд тусалж чадна.

**Редактор:** *Та энэ ховордсон зүйлийг хамгаалах талаар арав гаруй жил ажиллажээ. Энэ жилүүдэд юу өөрчлөгдөж, өнөөгийн хамгааллын салбарын хандлагыг та юу гэж дүгнэх вэ?*

**БК:** Бодит байдал дээрээ манай улсад ховордсон зүйлийг (ихэвчлэн том муур) хамгаалах, нөхөн сэргээх тал дээр их зүйл хийж байгаа боловч бөхөнгийн хамгаалалд ажиглагдаж байгаа өнөөгийн хандлагын талаар би үнэндээ өөдрөг ямар зүйл хэлж чадахгүйнээ. Байгаль хамгаалах яамны тушаал шийдвэрээр бөхөн нь ойрын хугацаанд ОХУ-ын Улаан номонд орох хэдий ч би хувьдаа энэ нь бөхөнг эсэн мэнд үлдэхэд туслах болно гэдэгт итгэлтэй биш байна ...



## Дурсамж

### Николай Ткачевийн дурсгалд



Николай Николаевич хүү Алексейн хамт. © Е. Полонский

Астрахан мужийн Степной дархан газрын байцаагч, жолооч Николай Ткачев 2016 оны 4 сарын 15-нд нас барлаа. Энэ гайхалтай хүн анх байгуулагдсан өдрөөс нь эхлэн дархан газарт ажиллаж байсан (2000 оны 4 сарын 5). Николай Николаевич байгалийн өв болох бөхөнг хулгайн анчдаас

хамгаалахад өөрийн эрүүл мэнд, амь насаа олон удаа эрсдэлд оруулж байв. Хүн бүр Николай Николаевичийн мэргэжлийн ур чадвар (тэр бөхөнгийн түүхийн талаар бүгдийг мэдэж байсан), даруу төлөв, цөөн үгтэй, хариуцлагатай, сайхан сэтгэлийг дурсан ярьж байна. Тэр жинхэнэ эр хүн байсан юм. Николай Николаевичийн ажлыг ОХУ-ын армид алба хаасны дараа Степной дархан газарт ажиллахаар ирсэн түүний хүү Алексей Ткачев үргэлжлүүлэх бөгөөд тэрээр сүүлийн дөрвөн жилийн турш эцгийнхээ баялаг туршлагаас маш их зүйл сурч авсан. Тэр үнэлэгдэж чадахаар залгамжлагч болж байна.

“Бөхөнгийн мэдээ” сэтгүүлийн редакцийн ажилтнууд Степной дархан газрын ажилтнуудын өмнөөс гашуудаж, Николай Ткачевын гэр бүл, хайртай хүмүүст чин сэтгэлийн эмгэнэл илэрхийлж байна.

### Мария Карлстеттерын дурсгалд

Мария Карлстеттер бол Германд долдугаар сард болсон авто замын ослоор харамсалтайгаар нас барсан, бөхөн хамгаалахад чухал хувь нэмэр оруулсан, байгаль орчныг хамгаалах ажилтан хүн юм.

Мария Төв Азийн бүс нутгийн газар нутгийн тогтоц, байгаль, соёлын өргөн хүрээтэй мэдлэг, сонирхолтой, туршлагатай байгаль хамгаалагч, биологич хүн байв. Өөрийн судалгааны ажлаа хийж дууссаны дараа тэрээр бүс нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбоотой төсөл, эко аялалын дэд бүтэц болон хил дамнан тусгай хамгаалалттай газар нутгийг бий болгох зэрэг янз бүрийн үйл ажиллагааны чиглэлтэй байгууллагад ажиллаж байв. Мария Зэрлэг Амьтдыг Хамгаалах Нийгэмлэгтэй хамтран Афганистанд, дараа нь Узбекистан, Казахстанд, Тажикстанд Амьтан, ургамал хамгаалах олон улсын

нийгэмлэгтэй хамтран ажиллаж байсан.

2009 оноос хойш 5 жил хугацаанд Амьтан, ургамал хамгаалах олон улсын нийгэмлэгийн Бөхөнгийн хөтөлбөр хариуцсан менежерийн хувьд, Мария Устюртын бөхөнгийн популяцийг хамгаалах байгаль орчны болон практик үйл ажиллагааг идэвхжүүлэх, ойлгуулах талаар томоохон алхам хийж чадсан. Энэ төслөөр дамжуулан Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг, Бөхөн хамгаалах холбоотой ойр дотно хамтран ажиллаж байв. Тэрээр орон нутаг, бүс нутаг, дэлхийн хэмжээнд энэ ховор зүйлийн талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан бөгөөд энэ зүйл мэнд үлдэх боломж байгаа гэдгийг жил ирэх бүрт баталгаажуулсан хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх талаар хүчин чармайлт гарган

ажиллаж байв. Энэ төслийн хүрээнд Мария Устюртын бөхөнгийн популяцийн талаарх бидний мэдлэгийг нэмэгдүүлэх, телеметрийн судалгаа, газар дээр практик үйл ажиллагааг хийж хэрэгжүүлэх, Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлийн конвенцитай гэрээ болон олон талт хэлэлцээр хийх зэрэг дээд шатны ажлыг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн юм. Мария Казахстан гаалийн албаны үйлчилгээнд хууль бус бөхөнгийн эвэр илрүүлэхэд үнэрч нохойг ашиглах шинэлэг санаачлагыг сэдэж эхлүүлсэн. Учирч буй сорилт, бэрхшээлийг үл хайхран Мария байнга шинэчлэлт өөрчлөлт хийх эрмэлзэлтэй байсан юм.

Гэр бүл, найз нөхөддөө ойртох хүсэлдээ хөтлөгдөн Мария 2013 онд Герман руу буцаж нүүсэн боловч Төв Азийг сонирхох өөрийн хүслээ үл гээн, Төв Азийн хөхтөн амьтдын санаачлага (САМИ) хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих, 2014 оны 11 сард Зэрлэг амьтдыг нүүдэллэдэг зүйлийг хамгаалах конвенцид оролцогч талуудын хурлаар батлагдсан Ажлын хөтөлбөрийг боловсруулахад, мөн Герман руу буцахаасаа өмнө Төв Ази, Энэтхэг даяарх байгаль орчны төслүүд дээр зөвлөхөөр ажиллаж байв. Мария хөдөө хээрт, явган аялах, ууланд авирах, гэрэл зураг дарах дуртай байсан бөгөөд амарч байхдаа иогоор хичээллэн зураг зурах хоббитой



Мария Карлстеттер. © FFI

байсан. Бүс нутагт Мариятай хамтран ажиллаж байсан хамт олон түүний чин сэтгэл, энэрэнгүй сайхан сэтгэл, бусдад урам зориг өгдөг зан чанарыг дурсаж байна. Мариятай ойр дотно хамтран ажиллаж, онцгой зүйлийг мэдэрч байсан бидний хүн бүр амьдарч буй дэлхийдээ өөрчлөлт хийх цуцашгүй хүсэлтэй мэргэжлийн, мэдлэгтэй найзыгаа үргэлж санан дурсах болно.

## Талархал

Бид Бөхөн хамгаалах холбооны ажлыг мөнгөн хандив, цаг хугацаараа дэмжин ажилладаг бүх хүмүүст гүн талархал илэрхийлэхийг хүсч байна. Ялангуяа Зэрлэг амьтан хамгаалах сүлжээний ажилтнууд, сайн дурынханд тэдний дэмжлэг, зөвлөгөө болон сүүлийн үеийн үйл ажиллагаанд өгөөмөр хандив өгч буй АНУ-ын олон нийтийн гишүүдэд талархаж байна. Бид энэ хэвлэлийг дэмжиж ажилласан ЗАНЗХК, Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь салбар, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятадын салбар зэрэг байгууллагад гүнээ талархаж байна.



SAIGA CONSERVATION ALLIANCE

**Бөхөн хамгаалах холбоо**  
**[www.saiga-conservation.org](http://www.saiga-conservation.org)**  
**Бөхөнгийн мэдээллийн нөөцийн**  
**төв:**

**[www.saigaresourcecentre.com](http://www.saigaresourcecentre.com)**

**Saiga Merchandise:**  
**[www.saigacraft.org](http://www.saigacraft.org)**

**Email: [mail@saiga-conservation.com](mailto:mail@saiga-conservation.com)**

**© Saiga Conservation Alliance 2016 /**  
**Registered charity England and Wales**

© Андрей Гилёв,  
Карина Каренина